

# **Аламеда мужийн сонгогчдын бүртгэлийн алба – Санал хураалтын төвийн төлөвлөгөө**

Удиртгал.....	3
Оршил.....	3
Аламеда мужийн сонгогчдод зориулсан Сонгогчийн сонголтын тухай хууль.....	4
<b>1 дүгээр бүлэг: Сонгуулийн зохион байгуулалтын төлөвлөгөө .....</b>	<b>5</b>
Шуудангаар санал өгөх үйл явц.....	5
Шуудангаар өгсөн саналыг нэгтгэн авах .....	6
Шуудангаар санал өгөх боломж .....	6
Саналын хуудсаа өгөх байршлууд.....	8
Санал өгөх төвүүд.....	9
Сонгогчийн бүртгэл.....	11
Саналын хуудас нөхөж авах.....	11
Санал хураалтын төвд саналаа хүртээмжтэйгээр, хялбар өгөх.....	11
Хэлний туслалцаа .....	12
Санал хураалтын төвийг хуваарилан байрлуулахад харгалзан үзэх зүйлс.....	13
Сонгуулийн ажилтнуудын бүрэлдэхүүн.....	15
Сонгогчдын цахим бүртгэлийн жагсаалт (Электрон таблет) .....	16
<b>Хүрч үйлчлэх .....</b>	<b>16</b>
<b>2 дугаар бүлэг: Сонгогчийн сонгуулийн боловсрол болон хүрч үйлчлэх төлөвлөгөө .....</b>	<b>18</b>
<b>1 дүгээр хэсэг: Сонгогчтой холбоо барих - Ерөнхий.....</b>	<b>20</b>
<b>Олон нийтийн оролцоо ба Сонгогчдод мэдлэг олгох материал .....</b>	<b>22</b>
Шууданг шууд илгээх.....	23
Сонгогчдод мэдлэг олгох цахим хуудас.....	23
<b>2 дугаар хэсэг : Сонгогчтой холбоо барих-Хэлний цөөнхийн бүлэг .....</b>	<b>24</b>
<b>3 дугаар хэсэг: Сонгогчтой холбоо барих-Тусгай хэрэгцээт сонгогч.....</b>	<b>26</b>
Сонгуулийн ажилтнууд.....	28
<b>4 дүгээр хэсэг: Санал хураалтын төвүүд, саналын хуудсаа үлдээх байршлын мэдээлэл... ..</b>	<b>28</b>
Санал хураалтын төвийн байршлууд.....	28
Саналын хуудсаа үлдээх цэгийн байршлууд.....	29
Онцгой байдлын төлөвлөгөө.....	30

Санамсаргүй тохиолдлын төлөвлөгөө.....	31
<b>5 дугаар хэсэг: Санал хураалтын төв дэх саналын хуудасны аюулгүй байдал, нууцлалын төлөвлөгөө .....</b>	<b>32</b>
<b>6 дугаар хэсэг: Төсөв .....</b>	<b>33</b>
<b>24 цаг саналын хуудас хүлээж авах хайрцгийн жагсаалт .....</b>	<b>33</b>
<b>Санал өгөх төвүүдийн байршил .....</b>	<b>36</b>
<b>Олон нийтийн түншүүд .....</b>	<b>41</b>
<b>Хэлний хүртээмжтэй байдлын зөвлөх хороо болон Санал өгөх хүртээмжтэй байдлын зөвлөх хорооны гишүүн байгууллагууд .....</b>	<b>46</b>

## Удиртгал

Энэхүү Тойргийн сонгуулийн зохион байгуулалтын төлөвлөгөөний зорилго Сонгогчийн сонголтын тухай хуулийн дагуу сонгуулийн хэрхэн зохион байгуулахыг мэдээлэх юм.

Аламеда мужийн Сонгогчийн бүртгэлийн алба нь Сонгогчийн сонголтын тухай хуулийг өөрийн тойргийн хэмжээнд амжилттай хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийн дэмжлэг, санал, шүүмжийг авахын чухлыг ойлгон ажилладаг. Эхний төлөвлөгөөг боловсруулах, шинэчлэх явцад олон нийтийн түншүүдтэй нийтийн зөвлөлдөх уулзалтууд хийсний дараа Сонгогчийн бүртгэлийн алба болон сонгогчдод хүрч үйлчлэх багууд нь Хэлний хүртээмжтэй байдлын зөвлөх хороо болон Санал хураалтын зөвлөх хороонуудтай хамтран ажиллах болно.

Сонгуулийн зохион байгуулалтын төлөвлөгөө нь хоёр хэсэгт хуваагдана:

*Төлөвлөгөөний 1* дүгээр хэсэгт сонгуулийн зохион байгуулалтын хүрээг хамрах бөгөөд үүнд шуудангаар саналаа өгөх үйл явц, санал хураалтын төвүүд болон саналын хуудас өгөх байршил, байршлын тоо, санал хураалтын төвд тавигдах шаардлага, олон нийтийн санал мэдэгдлийг авч үзэх зэрэг багтана.

*Төлөвлөгөөний 2* дугаар хэсэгт Калифорнийн сонгуулийн тухай хуулийн 4005(a)(10)(I)(i) тусгаснаар нийцүүлэн сонгогчдын мэдлэг, сонгогчдод хүрч үйлчлэх зэргийг багтаана. Мөн сонгогчдын ерөнхий холбоо барих мэдээлэл, хэлний цөөнхийн бүлэг, тусгай хэрэгцээт сонгогч, санал хураалтын төв, санал өгөх байршлын мэдээлэл, санал хураалтын төвийн саналын хуудасны аюулгүй байдал, нууцлалын төлөвлөгөө болон төсвийн хэсэг багтана.

## Оршил

Калифорнийн Сонгогчийн сонголтын тухай хууль (CCX) буюу Сенатын хуульд (SB) 450 (Allen, D-26) нь 2016 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр гарын үсэг зурж, хууль болгосон бөгөөд Калифорнийн Сонгуулийн тухай хуульд 4005 гэсэн хэсгийг нэмж, тойргийн хэмжээнд Удирдлагын зөвлөлөөс баталсны дагуу тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд сонгуулийг шуудангаар явуулах боломжийг бүрдүүлсэн юм. Сонгогчийн сонголтын тухай хуулийн дагуу сонгууль болохоос 29 өдрийн өмнөөс эхлэн сонгогчдод саналын хуудсыг шуудангаар хүргүүлэх бөгөөд тойрог бүр иргэд, олон нийтийн саналыг харгалзан нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд сонгогчид саналын хуудсаа үлдээх цэгүүд болон санал хураалтын төвийг байгуулна. Сонгогчийн сонголтын тухай хуулийн санал хураалтын загварын дагуу орон нутгийн санал хураалтын төвийг санал хураалт болохоос 10 өдрийн өмнө нээж, санал хураалтын өдөр эдгээр төвийг хаах шаардлагатай.

Калифорнийн захирагч КОВИД-19 цар тахлаас үүссэн нөхцөл байдлын улмаас 2020 оны 5 дугаар сарын 08 болон 2020 оны 6 дугаар сарын 03-ны өдрүүдэд N-64-20 болон N-67-20 дугаартай захирамж гаргаж, Ассемблейн АВ860 дугаартай хуульд гарын үсэг зурсан бөгөөд үүний дагуу санал өгөх эрхтэй сонгогч нь сонгуулийн саналын хуудсыг шуудангаар хүлээн авах, улмаар 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн ээлжит сонгуулийн үеэр санал хураалтын төвд биечлэн ирж саналаа өгөх шаардлагыг тавьснаар Сонгогчийн сонголтын тухай хуулийг хэрэгжүүлдэггүй тойргийн хувьд Сонгогчийн сонголтын тухай хуультай төстэй загвараар сонгуулийг зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн юм. Сонгуулийн тухай хуулийн 1602 (a) (b) болон (c) хэсэгт заасны дагуу Сонгогчийн сонголтын тухай хуультай төстэй сонгуулийн загварт 10,000 сонгогч тус бүрд биечлэн ирж саналаа өгөх нэг (1) цэг, 15,000 сонгогч тус бүрд саналаа үлдээх хайрцаг нэг (1) байна. Эдгээр захирамжийг гаргаснаас хойш Аламеда мужийн сонгогчдын бүртгэлийн алба нь 2020 оны 11 дүгээр сарын 03-

ны өдрийн ээлжит сонгууль, 2021 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн Калифорнийн захирагчийг эргүүлэн татах сонгууль гэсэн Сонгогчийн сонголтын тухай хуультай төстэй загварын хоёр сонгуулийг амжилттай зохион байгуулсан.

Калифорнийн захирагч нь шуудангаар санал өгөх саналын хуудсыг бүртгэлтэй сонгогч тус бүрд илгээхийг орон нутгийн хэмжээнд ажиллаж буй сонгуулийн нийт албан хаагчдад үүрэг болгосон Ассемблейн 37 (AB37) дугаар хуульд 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр гарын үсэг зурсан. Уг хууль нь сонгогч зайнаас хүртээмжтэй хэлбэрээр баталгаат шуудангаар санал өгөх системийг ашиглан аль ч сонгуульд саналаа өгөхийг зөвшөөрөхийг тойргийн сонгуулийн албан хаагчдад даалгасан. AB37 нь Шуудангаар санал өгөх ажиглах систем нь тусгай хэрэгцээт сонгогчдод хүртээмжтэй байх шаардлагыг тавьдаг.

Аламеда мужийн сонгогчдын бүртгэлийн алба ССХ болон тус хуультай адил төстэй загваруудын дагуу дараах томоохон сонгуулиудыг амжилттай явуулсан:

- 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Ерөнхий сонгууль
- 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн Калифорни муж улсын захирагчийг эргүүлэн татах сонгууль
- 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн Мужийн захирагчийн анхан шатны сонгууль
- 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Мужийн захирагчийн ерөнхий сонгууль

### **Аламеда мужийн тойргийн сонгогчдод зориулсан Сонгогчийн сонголтын тухай хууль**

2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн Аламеда муж нь сонгуулиудыг Сонгогчийн сонголтын тухай хуулийн дагуу явуулсан. Сонгогчийн сонголтын тухай хууль нь сонгогч саналаа хэрхэн, хэзээ, хаана өгөх боломж, хувилбарыг нэмэгдүүлж өгдөг. Сонгогч нь өөрийн Шуудангаар санал өгөх саналын хуудсыг ердийн шуудангаар аливаа нэмэгдэл төлбөр шимтгэл, шаардлагагүйгээр хүргүүлэх, 24 цаг санал авах албан ёсны хайрцагт үлдээх эсвэл шуудангаар саналын хуудсаа тойргийн хэмжээнд байршуулсан 100 санал хураалтын төвийн аль нэгд сонгууль болохоос арван (10) өдрийн өмнө өгөх боломжтой.

Санал хураалтын төвд сонгогч нь сонгууль болохоос арван (10) өдрийн өмнө биечлэн очиж саналаа өгөх, эсхүл сонгуулийн өдөр хүртэл бүртгүүлж саналаа өгөх боломжоор хангагдсан байна. Тусгай хэрэгцээт сонгогчийн хувьд туслалцаа дэмжлэг авах, хялбар байдлаар санал тэмдэглэх төхөөрөмж ашиглаж болно. Англи хэлнээс өөр хэлээр ярьдаг сонгогчийн хувьд хэлний туслалцаа болон санал хураалтын материалыг олон хэл дээр авах боломжтой байна. Муж улсын хэмжээний сонгуулийг сонгогчийн сонголтын тухай акт дор зохион байгуулах явцад 100 санал хураалтын төв болон 66 албан ёсны 24 цаг санал үлдээх хайрцгийг тойргийн хэмжээнд засаг захиргааны нэгж бүрд байршуулсан байна.

## 1 дүгээр бүлэг: Сонгуулийн зохион байгуулалт

### Шуудангаар санал өгөх үйл явц

Санал Өгөх Төвийн Загвар сонгуульд оролцох эрхтэй бүх сонгогчдод албан ёсны Шуудангаар Санал Өгөх Саналын Хуудсыг шуудангаар илгээдэг.

Сонгогчийн шуудангаар санал өгөх багцад дараах зүйлс багтана:

- Шуудангийн төлбөрийг төлсөн хариу илгээх дугтуй
- Албан ёсны саналын хуудас
  - Өрсөлдөөний тооноос хамааран олон саналын хуудсыг багтааж болно
  - Хэрэв заасан бол сонгогчийн сонгосон хэлээр
- Саналын хуудасны боодол (саналын хуудсыг хэрхэн бөглөж буцаах тухай зааварчилгаа)
- ВСА-ийн цаг, байршлыг харуулсан вэбсайт болон утасны дугаарын холбоос бүхий мэдээллийн хавсралт, 24 цагийн саналын хуудас, саналын хуудсыг хянах.
- "Би саналаа өгсөн" наалт
- Хэрэв хамааралтай бол мэдээллийн нэмэлт материал

Сонгууль болохоос 29 өдрийн өмнөөс эхлэн албан ёсны саналын хуудсыг АНУ-ын Шуудангийн үйлчилгээний нэгдүгээр зэрэглэлээр хүргүүлнэ. Албан ёсны саналын хуудсыг цэргийн албанд болон гадаад улсад байгаа сонгогчид руу сонгууль болохоос 45 өдрийн өмнө шуудангаар хүргүүлнэ. Цэргийн албаны болон гадаад улсад байгаа сонгогчид өөрсдийн хариу илгээх дугтуйны шуудангийн төлбөрийг нэмэх ёстой.

Сонгогч нь саналаа тэмдэглэсэн саналын хуудсыг дараах байдлаар буцаан илгээнэ:

- шуудан (бэлтгэж хүргүүлсэн нэгдүгээр зэрэглэлийн буцаах дугтуйг ашиглан аливаа төлбөр шимтгэл, шаардлагагүйгээр)
- саналын хуудсыг санал хураалтын аль нэг төвд өгөх
- саналын хуудсыг 24 цаг санал авах хайрцагт үлдээх
- саналын хуудсыг санал хураах явуулын байршилд хүргэн өгөх
- саналын хуудсыг ACVOTE On The Go багт өгөх (сонгогчдийн саналын хуудсыг хүлээж авах явуулын үйлчилгээ)
- саналын хуудсыг "The Inmate program" буюу хоригдол хөтөлбөрөөр хүргүүлэх

Хэрэв сонгогч саналын хуудсаа хугацаанд нь хүлээн аваагүй, саналын хуудас гэмтсэн, үрэгдсэн, эсвэл тэд саналын хуудсандаа алдаа гаргасан тохиолдолд саналын хуудсыг шинээр солих хүсэлт гаргах боломжтой. Шуудангаар санал өгөх шинээр солих саналын хуудсыг шуудан, и-мэйл, эсвэл факсаар авах хүсэлт гаргах боломжтой. Шуудангаар санал өгөх саналын шинэ хуудсыг сонгогч руу шуудангаар илгээх эсвэл сонгогчдын бүртгэлийн албанаас ажлын цаг авч болно. Мөн сонгогчдийн бүртгэлийн албаны цахим хуудаст хандаж, "Ballot Will Call" үйлчилгээг ашиглан шуудангаар санал өгөх саналын хуудсыг 24 цаг дараа өөрийн биеэр очиж авахаар товлож болно.

Үндсэн хэл нь Англи хэл биш бүртгэлтэй сонгогчдод зориулсан хос хэл дээрх саналын хуудсыг нийт дөрвөн хэлээр бөглөх боломжтой. Үүнд: Хятад, Испани, Тагалог, Вьетнам хэл дээрх саналын хуудсууд багтана. Сонгогч нь санал хураалтад бүртгүүлэхдээ өөрийн санал өгөх хэлийг бүртгэлийн

анкет дээр тусгайлан зааж болно. Саналын хуудас, шуудангаар санал өгөхтэй холбоотой материал, сонгогчийн мэдээллийн гарын авлага зэрэг нь сонгогчийн сонгож тэмдэглэсэн хэл дээр илгээгдэнэ. Мөн Сонгуулийн тухай хуулийн 14201 хэсэгт заасны дагуу Бирм, Кхмер, Хинди, Солонгос, Лаос, Миен, Монгол, Пунжаби, Тэлуку хэл дээрх зорилтот тойргийн саналын хуудсыг бүх Санал өгөх төвөөс хүсэлт гаргасны дагуу факсаар авах боломжтой. Санал өгөх төв бүр бүх хэл дээрх факсын саналын хуудасны хуулбарыг гурав нугалах хэлбэрээр хэвлэсэн байна. Хүссэн хэл дээр хэлний дэмжлэг авах шаардлагатай гэж тодорхойлсон тойрогт амьдардаг бүртгэлтэй сонгогчид факсын саналын хуудсыг авах хүсэлт гаргаж болно.

Шуудангаар санал өгөх, хэлний дэмжлэг авах шаардлагатай сонгогчдын хэлний сонголтыг 14201 хэсэгт заасны дагуу тэдний сонгогчийн бүртгэлд бүртгэж, факсын саналын хуудсыг тухайн хэлээр автоматаар шуудангаар илгээнэ. 14201 хэсэгт заасан аль нэг хэлийг сонгосон боловч сонгогчийн бүртгэлдээ тухайн хэлийг дурдаагүй сонгогчид факсын саналын хуудас авах хүсэлт гаргаж болно. Факсаар саналын хуудас авах хүсэлт гаргасан хэлний хэрэгцээтэй сонгогчдын албан ёсны саналыг шуудангаар Англи хэл дээр авна. Факсын саналын хуудас авах хүсэлтийг шуудан, утсаар эсвэл онлайнаар илгээж болно. Дараа нь факсын саналын хуудсыг сонгогчид шуудангаар илгээнэ. Сонгогчдын бүртгэлийн алба болох (510) 272-6973 дугаарын утас, (510) 272-6982 дугаарын факс, [registration@acgov.org](mailto:registration@acgov.org) цахим шуудангийн хаягаар, биечлэн, эсхүл My Voter Profile аппликэйшн [www.acvote.org/mvp](http://www.acvote.org/mvp) руу цахимаар хандаж өөрийн сонгосон хэлийг өөрчлөх хүсэлт гаргаж болно.

### *Шуудангаар өгсөн саналыг нэгтгэн авах*

Тойргийн хэмжээнд сонгогчдын бүртгэлийн албаны хоёр ажилчин саналын хуудсуудыг хайрцаас гаргаж авахдаа тухай бүрт нь баримтжуулж, протокол үйлдэнэ. Баг тус бүрд ухаалаг утас өгөх бөгөөд үүнийг саналын хайрцаас саналын хуудсыг гаргаж, ажиглан хянах системд нэвтрүүлэхэд ашиглана. Ажиглан хянах системийг сонгогчдын бүртгэлийн албаны саналын хайрцаг хариуцсан зохицуулагчид хянан, хайрцгууд хоосорсон болохыг баталгаажуулна. Саналын хуудсыг битүүмжилсэн цүнхэнд хийж сонгогчдын бүртгэлийн албанд шууд хүргэж ирнэ. Хүргэгдэн ирсэн саналын хуудастай цүнхийг бусад ажилчид хүлээн авч саналын хуудсууд шүүхийн байранд ирсэн болохыг баталгаажуулна.

### **Шуудангаар санал өгөх боломж**

#### *Зайнаас хүртээмжтэй хэлбэрээр шуудангаар санал өгөх*

Бүртгэлтэй бүхий л сонгогчдын ашиглах боломжтой сонголт бол зайнаас шуудангаар санал өгөх систем бөгөөд энэ нь сонгогчид гэртээ тав тухтайгаар саналын хуудсаа бие даасан, хувийн байдлаар бөглөх боломжийг олгодог. Зайнаас шуудангаар санал өгөх талаарх мэдээллийг сонгогчийн мэдээллийн гарын авлага, сонгогчдын бүртгэлийн албаны цахим хуудас болон шуудангаар сонгогчдод илгээгдэнэ. Зайнаас шуудангаар санал өгөх систем нь анх цэргийн болон хилийн чанад дахь сонгогчид, тахир дутуу сонгогчид эсвэл унших болон саналын хуудас дээр тэмдэглэгээ хийхэд туслалцаа шаардлагатай сонгогчдод зориулагдсан байсан бол одоо энэхүү технологийг ашиглан гэрээсээ бие даасан хэлбэрээр саналаа тэмдэглэх боломжтой. Шуудангаар санал өгөх нь интернэтээр санал өгөх эсвэл онлайнаар саналын хуудсаа хүргүүлэх арга БИШ гэдгийг анхаарна уу. Сонгогчид зайнаас шуудангаар санал өгөх системд хандах хүсэлт гаргах шаардлагагүй. Харин сонгогчид сонгогчдын бүртгэлийн цахим хуудаст байрлах өөрсдийн "My

Voter Profile” руу нэвтэрч, сонгуулийн өдөр гэхэд саналын хуудсыг хэрхэн татаж авах, хэвлэх, бөглөх, сонгогчдын бүртгэлийн албанд хүргүүлэх зааврын хамт албан ёсны саналын хуудсаа авах боломжтой. Цахим шуудангаар хүргүүлсэн холбоосыг ашиглан сонгогч нь саналын хуудсыг уншихын тулд өөрийн төхөөрөмжид татан аваад өөрт тохирсон аргаар бөглөнө. Шуудангаар саналаа өгөх боломжийг ашиглаж буй сонгогч нь өөрийн бөглөсөн саналын хуудсыг дараах гурван аргын аль нэгээр буцаан хүргүүлж болно: стандарт шуудангаар илгээх, 24 цагийн турш санал авах хайрцагт үлдээх, санал хураалтын аль нэг төвд өгөх.

Саналын хуудсаа буцаан хүргүүлэх аргаас үл хамааран саналын хуудсыг дугтуйнд хийж өгнө. Сонгогчдод шуудангаар санал өгөх багц дотор илгээсэн дугтуйг ашиглахыг зөвлөж байна. Сонгогч нь сонгогчдын бүртгэлийн албаны (510) 272-6973 дугаарын утсаар холбогдож, эсхүл сонгогчдын санал хураалтын төв дээр биечлэн очиж, саналын хуудас буцаан илгээх дугтуйгаа нөхөн авч болно. Түүнчлэн сонгогч өөрийн дугтуйг ашиглаж болох боловч энэ тохиолдолд сонгогчийн тангаргийн хуудсыг хэвлэн гарын үсэг зурж, саналын хуудаст хавсаргасан байх шаардлагатай. Сонгогчид мөн өөрсдийн дугтуйг ашиглах боломжтой. Хэрвээ санал өгсөн хуудсыг стандарт шуудангаар зориулалтын бэлдэж өгсөн дугтуйг ашиглан хүргүүлэхэд шуудангийн хураамж төлөхгүй. Харин сонгогч *өөрийн* дурын дугтуйг ашиглан илгээх тохиолдолд шуудангийн төлбөрийг төлөх болно. Сонгогч бөглөсөн саналын хуудсыг Тангараг өргөх маягтын хамт буцааж илгээх ёстой.

### *Хоригдлууд Шуудангаар Санал Өгөх Хөтөлбөр*

Сонгогчдын бүртгэлийн алба нь хорих ангийн хоригдлууд шуудангаар санал өгөх хөтөлбөрийг ашиглан хоригдлуудад үйлчилгээ үзүүлдэг. Энэ бол хоригдлуудыг сонгуулийн санал хураалтад оролцуулах зорилготой сонгогчдын бүртгэлийн алба, Аламеда тойргийн Шерифийн газар болон бусад хууль сахиулах байгууллагууд хамтран ажилладаг үйл явц юм. Санал хураах “Drop Stop” тусгай арга хэмжээг хоригдлуудад мэдээлэл авч, санал өгсөн хуудсаа Сонгогчдын бүртгэлийн албаны багийн гишүүдэд шууд өгөх боломж олгох зорилгоор “Санта Рита” хорих газарт зохион байгуулна. Энэ үйл явцын хүрээнд Сонгогчдын бүртгэлийн алба хоригдлуудыг бүртгэж, одоогийн бүртгэлийг баталгаажуулж, санал өгөх эрх бүхий бүртгэлтэй хүмүүст саналын хуудас өгдөг. Шерифийн газар нь сонгогчийн бөглөсөн бүртгэлийн маягт болон хоригдлуудын шуудангаар санал өгөх өргөдлийг сонгогчдын бүртгэлийн албанд гараар хүргэдэг. Сонгогчдын бүртгэлийн алба нь сонгогчийн бүртгэлийн маягт болон шуудангаар санал өгөх өргөдлийг боловсруулдаг. Сонгогчдын бүртгэлийн алба нь сонгуулийн өмнө Шерифийн газартай уулзаж, сонгуулийн огноо, бүртгэлийн эцсийн хугацаа, шуудангаар санал өгөх хуудасны боломжит байдал (сонгуулийн өмнөх 29 хоног), саналын хуудас авах, хүргүүлэх зэргийг багтаасан хөтөлбөрийн хуваарийг тодорхойлдог. Шерифийн газар хоригдлуудад шуудангаар санал өгөх саналын хуудсыг хүргэдэг. Санал өгсөн хуудсыг Шерифийн алба авч сонгогчдын бүртгэлийн албанд сонгуулийн өдөр, эсхүл түүнээс өмнө илгээнэ.

### *“ACVOTE On The Go” хөтөлбөр*

“ACVOTE On The Go” хөтөлбөр нь эмнэлэгт хэвтсэн, тусгай хэрэгцээт эсвэл эрүүл мэндийн улмаас шалтгаалан гэрээс гарах боломжгүй сонгогчдын саналыг хүлээн авах, саналын хуудсыг бөглүүлэн сонгуулийн хороонд өгүүлэх зорилготой бөгөөд сонгуулийн томилогдсон хоёр ажилтан захиргааны болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулах болно. Сонгогчдын бүртгэлийн алба цаашдын сонгуулийн саналын хуудасны тэмдэглэгээ хийх боломжуудыг судалж

байна. Хэрэв хүсэлт гаргавал мужийн тойргийн сонгогчдын мэдээллийн гарын авлагын том үсэгтэй хувилбаруудыг хараа муутай эсвэл харааны бэрхшээлтэй сонгогчдод өгөх боломжтой. Энэхүү үйлчилгээг авах шаардлагатай сонгогчид саналаа цаг тухайд нь шуудангаар авах талаарх зааварчилгааг авахыг хүсвэл СБА-тай холбогдож болно. Сонгууль болохоос 29 хоногийн өмнө сонгогчид сонгогчдын бүртгэлийн газрын (510) 272-6973 дугаарын утсаар эсвэл [onthego@acgov.org](mailto:onthego@acgov.org) цахим шуудангийн хаягаар холбогдож, "ACVOTE On The Go" хөтөлбөрт бүртгүүлэх боломжтой.

### "Ballot Drop Stop Tour"

СБА-ны Санал Хураах "Drop Stop" аян нь сонгогчид санал өгсөн саналын хуудсаа хүргүүлэх, удахгүй болох сонгуулийн талаар мэдээлэл авах, санал өгөхөөр бүртгүүлэх зэрэг боломжийг олгодог. Аян нь сонгууль тус бүрээс 28 хоногийн өмнө эхэлж, сонгууль бүрээс дөрөв хоногийн өмнө дуусдаг. Санал Хураах "Drop Stop" Аян нь тусгай хэрэгцээт иргэд, ахмад настнууд, залуучууд, хэл, шашин шүтлэгт суурилсан байгууллагууд, амьтдын хорогдох газар, худалдааны төвүүд, үйлчилгээ дутмаг авдаг, орон байргүй иргэдэд чиглэсэн. Байршлууд нь номын сан, хотын танхим, ахмадын төв, Тойргийн хэмжээн дэх олон нийтийн арга хэмжээ, фестиваль зэргийг багтаана. Санал Хураах "Drop Stop" аян болон боломжит байршлуудын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл санал үлдээх байршлыг мэдэх хүсэлт хэрхэн гаргах тухай тайлбарыг [www.acvote.org/dropstop](http://www.acvote.org/dropstop) холбоосоор Санал Хураах "Drop Stop" хуудаснаас үзнэ үү.

### **Саналын хуудсаа үлдээх байршлууд**

#### *Сонгуулийн тухай хуулийн 4005 дахь хэсэг*

Калифорнийн сонгуулийн тухай хуульд тойргийн зүгээс сонгогчдод зориулан Саналын хуудсаа үлдээх цэгийг бэлтгэх параметрийг тогтоосон байдаг. 15,000 бүртгэлтэй сонгогч тус бүрд нэг (1) саналын хуудсаа үлдээх цэгийг сонгууль болохоос 28 өдөр, түүнчлэн сонгуулийн өдрийг оруулаад нийтдээ 29 өдрийн хугацаанд байршуулсан байна.

24 цаг санал үлдээх хайрцгийн тоог сонгууль болохоос өмнөх 88 дахь өдрийн байдлаар бүртгэгдсэн тус Тойргийн сонгогчдын бодит тооноос хамаарч тогтооно. Одоогоор бүртгэгдсэн нийт сонгогчид үндэслэн СБА нь 24 цаг санал үлдээх 63 хайрцгаар хангах шаардлагатай.

<b>Шаардлага</b>	
Саналаа үлдээх цэгийн байршил: (Бүртгэлтэй 15000 сонгогч бүрд 1)	63

#### *24 цаг санал үлдээх хайрцаг*

Одоогийн байдлаар сонгогчийн бүртгэлийн алба нь тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 24 цаг санал үлдээх хайрцгийн нийт 66 цэгийг бэлтгэсэн байна. Саналын хуудсыг слот аргаар дамжуулан саналын хайрцагт хийнэ. 24 цагийн турш санал авах хайрцгийг дөрвөн удаагийн нөхөн сонгууль болон муж улсын хэмжээний дөрвөн удаагийн сонгуульд ашигласан.

Сонгогчийн бүртгэлийн алба нь 24 цагаар санал авах хайрцгийн загвар болон байршлыг тогтоохдоо мужийн дүрэм журам, зохицуулалтыг дагаж мөрдсөн болно. Сонгогчийн бүртгэлийн



алба нь 24 цагийн саналын хайрцгийг бүх нийтийн хүрээнд байршуулахаар хотын болон тойргийн албан тушаалтнууд, орон нутгийн эрх зүй, сонгогдсон албан тушаалтнууд, олон нийтэд түшиглэсэн байгууллагууд, хэлний нийгэмлэгүүд, тусгай хэрэгцээт иргэдийн нийгэмлэгүүд болон Аламеда муж дахь хотуудтай хамтарсан. 24 цагийн саналын хайрцаг байрлуулах асуудлыг хэлэлцэхдээ дээр дурдсан Сонгуулийн Тухай Хуульд заасан шалгуурыг баримталсан.

Англи хэлнээс өөр хэлээр ярьдаг сонгогчийн хувьд санал өгөх бололцоог нь бүрдүүлэх үүднээс 24 цаг санал авах хайрцагт "Санал авах албан ёсны хайрцаг" гэсэн тэмдэглэгээг тухайн шаардлагатай хэл дээр байрлуулсан болно.

### **Санал өгөх төвүүд**

Сонгогчийн сонголтын тухай хуулийн (VCA) загвар сонгуулийн дагуу Санал өгөх төвүүд нь тогтсон санал авах байруудын өмнө нь ажиллаж байснаас олон хоног ажиллах шаардлагатай. Санал өгөх бүх төв сонгуулийн өдрөөс өмнө гурав (3) хоногийн хугацаанд мөн сонгуулийн өдөртэй нийлээд, нийт дөрөв (4) хоногийн турш ажиллана. Сонгуулийн өдөр болохоос өмнөх арав (10) хоног, сонгуулийн өдөртэй нийлээд арван нэгэн (11) хоногийн турш 20 байршилд ажиллана.

Калифорнийн сонгогчийн сонголтын тухай хуульд заасан хэмжигдэхүүнээр аль тойрог санал өгөх төвөөр сонгогчдыг хангах болохыг заасан байдаг ба:

- Сонгуулийн өдрөөс өмнөх арав (10) хоногоос эхлэн сонгуулийн өдрөөс өмнөх дөрөв дэх өдөр хүртэл нийт долоон (7) хоногийн хугацаанд бүртгэлтэй 50,000 сонгогч тутамд нэг Санал өгөх төвийг сонгууль болж буй нутаг дэвсгэрт ажиллуулах ёстой.
- Сонгуулийн өдрөөс өмнөх гурав (3) хоногоос эхлэн, сонгууль болох өдөр, нийт дөрөв (4) хоногийн хугацаанд 10,000 сонгогч тутамд нэг Санал өгөх төвийг сонгууль явуулж буй нутаг дэвсгэрт ажиллуулах ёстой.

Санал өгөх бүх төв нь санал өгөхөд хүртээмжтэй тоног төхөөрөмж, хэлний дэмжлэг үзүүлэхүйцээр тоноглогдсон байх бөгөөд сонгогчдод тухайн өдөртөө бүртгүүлэх, санал өгөх боломжийг олгох сонгогчийн түх хугацааны бүртгэлийг санал болгоно. Түүнчлэн сонгогчдыг товлосон ганц санал авах байраар хязгаарлахгүй бөгөөд Аламеда муж дахь санал өгөх төвийн аль нэгэнд очиж санал өгөх боломжтой.


Сонгогчдод илүү сайн үйлчлэхийн тулд Аламеда муж нь хангалттай байршил, ажилтан байгаа үед, мөн энэ нь сонгогчдод ашиг тустай байх үүднээс хамгийн бага шаардлагаас дээгүүр 11 өдрийн Санал өгөх төвийг нэмэлтээр, хамгийн бага шаардлагаас дээгүүр 4 өдрийн зургаан (6) санал өгөх төвийг нэмэлтээр ажиллуулахаар төлөвлөж байна. Санал өгөх бүх төвийн ажиллах цагийн хуваарь нь Сонгуулийн өмнөх өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд байна. Сонгогчдын бүртгэлийн албаны цахим хуудаст байршлын жагсаалтыг нийтлэх бөгөөд энэ нь тухайн байршлын чиглэлийг мөн зааж өгдөг. Сонгуулийн өдөр сонгуулийн тухай хуулийн (Сонгуулийн тухай хууль §4005) дагуу 07:00-20:00 цаг хооронд санал өгөх бүх төв сонгогчдод нээлттэй байна. Санал өгөх төвийн тоог сонгууль болохоос өмнөх 88 дахь өдрийн байдлаар бүртгэгдсэн тус Тойргийн сонгогчдын бодит тооноос хамаарч тогтооно. Одоогоор бүртгэгдсэн сонгогчдод үндэслэн доорх хүснэгтэд дурдсанчлан 11 өдрийн Санал өгөх төвийн доод хэмжээ 19, 4 өдрийн Санал өгөх төвийн тоо 75 байна. Сонгогчийн бүртгэлийн алба нь 11 өдрийн турш 20 санал өгөх төв, 4 өдрийн турш 80 санал өгөх төвөөр хангана.

Муж улсын хэмжээнд сонгуулийн тооцоо	СБА-ны бага шаардлага	Сонгогчдын бүртгэлийн албаны төлөвлөгөө
11 хоногийн турш Санал өгөх төвүүд (Бүртгэлтэй 50,000 сонгогч бүрт 1)	19	20
4 хоногийн турш Санал өгөх төвүүд (Бүртгэлтэй 10,000 сонгогч бүрт 1)	75	80

**Санал өгөх төвийн жишээ зургийг доор харуулав. Санал өгөх төвийн төлөвлөлт нь өрөөний хэмжээ, зохион байгуулалтаас хамаарч өөр байж болно.**

Зурагт:

1. Орох хаалганы ойролцоо байрлах Сонгогчдын мэдээллийн төв (2)
2. Саналын хуудас хэвлэх цэгийн ард байрлах Зөөвөрлөлтийн торон тэрэг (4-5)
3. Санал өгөх төвийн сагстай тэрэг (3)
4. Орох хаалганы ойролцоо байрлах Саналын хуудас шалгах цэг
5. Саналын хуудас шалгах цэгийн хажууд байрлах Саналын хуудас шаардлагатай үед хэвлэх байршил
6. Шар өнгийн шуудангаар өгөх саналын хуудасны хайрцаг
7. Цэнхэр өнгийн нөхцөлт/түр саналын хуудасны хайрцаг
8. Оюу ногоон өнгийн албан ёсны саналын хайрцаг
9. Хэвлэмэл саналын хуудсаар санал өгөхөд зориулсан бүхээг (2) хөндлөн урсгалаас зайдуу хананд байрлана
10. Тусгай хэрэгцээт сонгогчдод зориулсан бүхээг болон Санал тэмдэглэх төхөөрөмжөөс хол зайд Санал өгөх бүхээг (4) байрлана
11. Тусгай хэрэгцээт сонгогчдод зориулсан бүхээгийн эсрэг талд Санал тэмдэглэх төхөөрөмжүүд (4) байрлана.



## **Сонгогчийн бүртгэл**

*Санал өгөх төв – Сонгогчийн түр хугацааны бүртгэл*

Санал өгөх төвүүд нь санал авах байрны уламжлалт загвартай харьцуулахад илүү олон үйлчилгээг үзүүлдэг. Санал өгөх төвүүдэд үзүүлдэг өргөжүүлсэн үйлчилгээний нэг бол сонгогчийн бүртгэл болно. Сонгогчид аль нэг санал өгөх төвд санал өгөхийн тулд бүртгүүлэх, сонгогчийн бүртгэлээ шинэчлэх, түр зуурын санал өгөх боломжтой болсон. Сонгогчийн түр хугацааны бүртгэлийн дагуу санал өгөх эрхтэй болсон сонгогчид нөхцөлт/түр саналын хуудас/сонгогчийн бүртгэлийн маягтын дугтуйтай саналын хуудас хүлээн авна. Санал авах байрнаас ялгаатай нь сонгогчийн түр хугацааны бүртгэлийн дагуу сонгогчид санал өгөх үед тухайн сонгогчийн хэсгийн хорооны саналын хуудасны төрлийг санал өгөх төвүүдээс олгоно.

## **Саналын хуудас нөхөж авах**

Сонгогч саналын хуудсаа цаг тухайд нь хүлээн аваагүй, эсхүл санал тэмдэглэхдээ алдаа гаргасан бол саналын хуудас нөхөн авах хүсэлт гаргаж болно. Шуудангаар санал өгөх саналын хуудас авах тухай хүсэлтийг шуудан, цахим шуудан болон факсаар гаргаж болно. Нөхөн олгож буй шуудангаар санал өгөх саналын хуудсыг сонгогч руу шуудангаар илгээнэ. Сонгогч нь мөн сонгогчийн бүртгэлийн цахим хуудаст хандаж, "Ballot will call" үйлчилгээг ашиглан шуудангаар санал өгөх саналын хуудсыг 24 цагийн дараа өөрийн биеэр очиж авахаар товлож болно.

*Урьдчилан санал өгөх*

Сонгогч аль нэг санал өгөх төвд урьдчилан санал өгөх боломжтой (Сонгуулийн тухай хууль §14310). Бүртгүүлсэн гэж мэдэгдсэн боловч сонгуулийн бүртгэлийн ажилтнууд санал өгөх эрхийг нь шууд тодорхойлох боломжгүй байгаа сонгогч урьдчилсан саналын хуудсанд санал өгөх эрхтэй. Саналын хуудас, нөхцөлт/түр саналын хуудас/сонгогчийн бүртгэлийн маягт бүхий дугтуйг урьдчилсан саналын хуудас бөглөх үйл явц, журмын талаар бичсэн зааварчилгааны хамт; сонгогч гарын үсэг зурсан байх ёстой сонгогчийн бүртгэл, санал өгөх эрхийн тухай бичсэн нотолгоог сонгогчид олгоно. Урьдчилсан саналын хуудас бөглөсөн аливаа сонгогч сонгогчдын бүртгэлийн албаны цахим хуудас дээрээс санал өгсөн саналын хуудасныхаа төлөвийг хянах бол дугтуйнаас баримтаа урж авч болно. Дараа нь сонгогч саналын хуудсыг нөхцөлт/түр саналын хуудас/сонгогчийн бүртгэлийн маягт бүхий дугтуйд хийж битүүмжлэн, сонгуулийн төв оффис руу буцах баталгаатай урьдчилсан саналын хуудасны тэргэнд хийх ёстой. Сонгогчид саналыг нь тоолсон эсэхийг баталгаажуулахын тулд сонгогчдын бүртгэлийн албатай холбогдох эсвэл цахим хуудас ашиглах боломжтой.

## **Санал хураалтын төвд саналаа хүртээмжтэйгээр, хялбар өгөх**

Аламеда мужийн Сонгогчдын бүртгэлийн алба нь сонгогчдод хүртээмжтэй байдлыг бий болгохын тулд Сонгогчийн сонголтын тухай хуулийн хэрэгжилтийг анхааран үзэхийг зорьдог. Мөн санал өгөх төвийг сонгох, санал өгөх машинд тавигдах шаардлага, сонгуулийн ажилчдыг сургах, хуваарилах зэргийг тодорхойлох чухал шалгууруудын нэг бол хүртээмжтэй байдал юм. Сонгогчдын бүртгэлийн алба нь сонгогч бүрт аюулгүй, хүртээмжтэй, хараат бус санал өгөх туршлагыг хэрэгжүүлэхийг зорьдог ба зайнаас шуудангаар санал өгөх зэрэг өмнө нь бий болсон програмуудын хамт хялбар ашиглах боломжтой саналын хуудасны тэмдэглэгээний төхөөрөмжийг ашигладаг. Сонгогчдын бүртгэлийн алба нь санал өгөх бүх төвд хүртээмжтэй санал хураалтыг үргэлжлүүлэн явуулна.

Калифорнийн Төрийн нарийн бичгийн албаны хүртээмжтэй байдлыг шалгах хуудсыг ашиглан сонгуулийн санал өгөх төвүүдийг шаардлага стандартад нийцсэн эсэхийг баталгаажуулж өөрчлөлт оруулах эсийг тодорхойлно. Бүх санал өгөх байршлууд нь санал өгөхөд хялбар хүртээмжтэй байна.

Аламеда муж дахь Санал өгөх төв бүр хамгийн багадаа зургаан (6) Доминион саналын системийн ICX ашиглахад хялбар саналын хуудсыг тэмдэглэх төхөөрөмжөөр тоноглогдсон байдаг. Эдгээр төхөөрөмж нь бүх төрлийн саналын хуудсны төрөл, хэлний хувилбараар программчлагдсан байдаг. Санал өгөх төв бүрийн Саналын хуудас тэмдэглэх төхөөрөмж (BMD) нь түр болон байнгын хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод хувиараа болон бие даан санал өгөх эрхээ хэрэгжүүлэх боломжийг олгодог, АНУ-ын Тусгай хэрэгцээт иргэдийн тухай хуульд нийцсэн санал өгөх аргын төрөл бүрийн сонголттой онцлог, дагалдах хэрэгсэлтэй байдаг. "Хувиараа болон бие даан" гэдэг нь эдгээр төхөөрөмжийг ашиглан саналаа тэмдэглэхдээ өөр хүнд найдахгүйгээр, хэнд ч хэрхэн санал өгч буйгаа мэдэгдэхгүйгээр санал өгөх боломж олгож, нууц санал өгөх эрхийг хамгаална. Эдгээрт саналын хуудсыг удирдах, тэмдэглэх боломжтой сонгогчийн сонгосон дурын хослолд ашиглаж болох дүрс, аудио, мэдрэгчтэй интерфэйсүүд багтана. Мөн дэлгэц дээрх үсгийн хэмжээг өөрчилж, дэлгэцийн нягтралыг хар дэвсгэр дээр тод ялгагдах цагаан болгож сольж болно. Дээрх дэлгэцийн өөрчлөлтөөс гадна аудио мэдрэгчтэй интерфэйс товчлуур нь сонгогчдод саналын хуудсаа сонсох, ярианы чанга сул болон хурдыг (шаардлагатай бол) тохируулах, сонголтоо хийх боломжийг олгоно. Аудио мэдрэгчтэй интерфэйс нь мөн харгалзах Брайл үсгийн тайлбар, "Сорох ба үлээх" буюу сонголт хийх төхөөрөмжүүдийн оролт бүхий навигацийн бүх төрлийн том товчлууртай. Аливаа сонгогч санал өгөх үйл явцад тэдэнд туслах нэг (1) эсвэл хоёр (2) хүнтэй цуг ирж болно, үүнд сонгуулийн ажилчид багтана.

Нэг буюу хэд хэдэн саналын хуудас тэмдэглэх төхөөрөмжид асуудал илэрсэн тохиолдолд Сонгогчдын бүртгэлийн алба нь шаардлагатай бол аливаа төхөөрөмжийг солих үйл явцыг нэн даруй эхлүүлнэ. Солих үйл явц нь тухайн байршлын ашиглагдах боломжтой төхөөрөмж, хүчин чадлын хэрэгцээ, асуудлын хэр ноцтой байдлаас шалтгаалан дараалж явагдана.

Санал өгөх төв бүрийн хүртээмжтэй нэмэлт үйлчилгээнд санал өгөх нэмэлт хэсэг болон Санал өгөх төвийн үйл ажиллагааны туршид бүх сонгогчдыг чиглүүлэхэд бэлтгэгдсэн сонгуулийн ажилчид багтана. Санал өгөх төв бүрд байх хангамжид том бариултай үзэг, томруулагч болон гарын үсгийн зааварчилгаа багтана.

Бүх Санал өгөх төв нь Санал өгөх нэмэлт хэсгийг санал болгоно. Тээврийн хэрэгслээсээ буух боломжгүй эсвэл Санал өгөх байранд орж чадахгүй сонгогчид Санал өгөх төвийн гадна үйлчилгээ авах боломжтой. Тэмдэглэгээ нь сонгогчдод Санал өгөх нэмэлт хэсэг хаана байгаа болон тэндээс хэрхэн тусламж хүсэх талаар мэдээлэл өгнө.

Сонгуулийн ажилтнууд санал өгөх төвд ажиллахаасаа өмнө сургалтад хамрагдах шаардлагатай. Тус сургалт нь тусгай хэрэгцээт иргэдийн хүлээн авах чадвар, саналын хуудсанд тэмдэглэгээ хийхэд туслах хэрэгслийг хэрхэн ашиглах, сонгогчдод туслах талаар практик сургалтыг багтаасан. Сонгуулийн ажилтнууд Санал өгөх төвийн үйл ажиллагааны турш сонгогчдод тусална. Үүнд саналын хуудсанд тэмдэглэгээ хийх төхөөрөмжид тохиргоо хийх, түүнчлэн тусламж хүссэн сонгогчид туслах зэрэг багтана.

### **Хэлний туслалцаа**

Сонгогчдын бүртгэлийн албаны зорилго нь санал өгөх төвүүдэд шаардлагатай бүх хэлээр хэлний дэмжлэг үзүүлэх юм. Аламеда мужийн хувьд эдгээр хэлнүүд нь: Англи, Хятад, Испани, Тагалог, Вьетнам, Бирм, Кхмер, Хинди, Солонгос, Лаос, Миен, Монгол, Пунжаби, Тэлугу байна. Санал өгөх бүх төвөөс албан ёсны саналын хуудас, зорилтот тойрогт факсын саналын хуудас, нөхцөлт/түр саналын хуудас/сонгогчийн бүртгэлийн маягт бүхий дугтуй зэрэг санал өгөх бүх материалыг тэдгээр хэлээр өгнө.

Сонгогчдын бүртгэлийн албаны төлөвлөгөөнд сонгогчдод шаардлагатай хэлээр ярьж чаддаг, хоёр хэлтэй ажилтнуудыг ажилд авах явдал багтана. Хэрэв хоёр хэлээр ярьдаг ажилтан байхгүй бол санал өгөх төвийн ажилтнууд сонгогчдын бүртгэлийн албатай холбогдож, хэлний дэмжлэг үзүүлэх утасны шугамд сонгогчийг холбож өгнө. Түүнчлэн сонгуулийн ажилтнууд Төрийн нарийн бичгийн даргын санал болгосон орчуулагчийн үйлчилгээг сонгогчидтой холбох боломжтой болно. Энэ үйлчилгээ нь Аламеда мужийн шаардлагатай бүх хэлийг хамарна. Сонгогчдод хэлний тусламж үзүүлэх утасны талаар сонгогчийн мэдээллийн гарын авлага, шуудан илгээх, шуудангаар санал өгөх хэсэг, сонгогчдын бүртгэлийн цахим хуудас, хэлний хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэргээр мөн олон нийтийн арга хэмжээний үеэр мэдээлэл авах боломжтой.

Сонгогчийн мэдээллийн сангаас авсан газарзүйн зураглал болон хэлний мэдээлэл дээр үндэслэн сонгогчдын бүртгэлийн алба нь хоёр хэлтэй ажилтнуудыг сонгогчдын хэрэгцээт газруудад хуваарилах боломжтой. Хэрэв мужийн хэмжээнд санал өгөх төвүүдэд хэл болгоноор ярьдаг сонгуулийн ажилчид хүрэлцэхгүй байвал бид тухайн хэлээр хамгийн их дэмжлэг авах шаардлагатай гэж тодорхойлсон санал өгөх төвүүдэд хоёр хэлтэй сонгуулийн ажилчдыг хуваарилах зорилт тавина. Хоёр хэлтэй сонгуулийн ажилтны тоог сонгууль болохоос 60 хоногийн өмнө тогтоох ба бидэнд дунджаар 2-5 сонгуулийн ажилчид байна. Тухайн үед санал өгөх төвүүд зорилтот тойргуудын ойролцоо байгаа эсэхийг тодорхойлох шинжилгээ хийдэг. Үүний дагуу хоёр хэлтэй сонгуулийн ажилчдыг томилно.

### **Санал өгөх төвийг хуваарилан байрлуулахад харгалзан үзэх зүйлс**


Сонгогчдын бүртгэлийн алба нь доор дурдсан Сонгогчийн сонголтын тухай хуульд заасан 14 шалгуурыг ашигладаг.

Эдгээр шалгуур нь:

1. Нийтийн тээвэрт ойр
2. Шуудангаар санал өгөх нийгмийн бүлэгтэй ойр
3. Хүн амын төвлөрөлтэй ойр
4. Хэлний цөөнхийн нийгмийн бүлэгтэй ойр
5. Тусгай хэрэгцээт сонгогчидтой ойр
6. Тээврийн хэрэгсэл бага эзэмшдэг нийгмийн бүлэгтэй ойр
7. Орлого багатай нийгмийн бүлэгтэй ойр
8. Сонгогчийн бүртгэлийн хувь багатай нийгмийн бүлэгтэй ойр
9. Газарзүйн хувьд тусгаарлагдсан хүн ам, түүний дотор уугуул Америкийн нутаг дэвсгэртэй ойр
10. Хүртээмжтэй байдал ба үнэгүй зогсоол
11. Санал өгөх төв болон саналын хуудас өгөх газар хүртэлх явах зай болон хугацаа
12. Шуудангаар санал өгөх саналын хуудас авах боломжгүй тусгай хэрэгцээт сонгогчдод зориулсан өөр аргуудын хэрэгцээ
13. Санал өгөх төв болон Саналын хуудас өгөх газруудын ойролцоох замын хөдөлгөөний төлөв
14. Гар утсаар Санал өгөх төвүүдийн хэрэгцээ

Эдгээр шалгуурын заримыг тооцоолоход хэд хэдэн боломжит эх сурвалжаас цуглуулсан өгөгдлийг (жишээ нь, Америкийн нийгмийн бүлгийн судалгаа, сонгогчдын бүртгэлийн албаны сонгогчийн мэдээллийн сан, АС транзит автобусны зогсоол, Bart буудал) ашиглана.

Сонгогчдын бүртгэлийн алба нь тухайн суурин газарт хангалттай санал өгөх төвөөр хангагдсан эсхийг баталгаажуулахын тулд шалгуурт дурдсан хүн ам, газарзүйн байршлыг харуулсан давхаргын зураглалтай харьцуулан санал өгөх төвийн боломжит байршлыг тодорхойлдог. Аламеда муж нь санал өгөх төвүүдийн хамгийн сайн байршлыг тодорхойлохын тулд “Inclusive Democracy Vote Center Siting Tool” хэрэгслийг ашигладаг. Энэ хэрэгсэл нь хэрэгцээт шалгууруудыг тооцоолж, санал өгөх төвүүдийн байршуулах тохиромжтой газруудыг тодорхойлдог. Доорх зургийг үзнэ үү.



Энэ хэрэгслээс гадна манай газарзүйн зураглал хэсэг нь санал өгөх төв бүрийн эргэн тойронд 1 миль зайтай буфер бүсүүдийг харуулсан давхарга үүсгэдэг. Энэ нь ихэнх сонгогчид санал өгөх төврүү очихын тулд нэг миль газраас дээш явах шаардлагагүй байхад туслах зорилготой юм. 10,000 сонгогчтой газрыг харуулсан нэмэлт давхарга нь эдгээр газарт хангалттай тооны санал өгөх төвүүд байгааг баталгаажуулахад тус болдог. Доорх зургийг үзнэ үү.



Энэ үйл ажиллагаанд мөн олон нийтийн саналыг харгалзан үздэг. Сонгогчдын бүртгэлийн алба нь сонгогчдын бүртгэл багатай, Шуудангаар санал өгөх хандлагатай нийгмийн бүлэгтэй ойр байхыг чухалчилдаг, учир нь эдгээр нийгмийн бүлэг биечлэн санал өгөх эсвэл санал өгөх төв бүрд байдаг сонгогчийн түр хугацааны бүртгэлийн давуу талыг ашиглах магадлал өндөр байдаг. Мөн санал өгөх талбайн хэмжээ, боломжит үнэгүй зогсоол, сонгогчид тухайн байршлыг мэдэх эсэхийг харгалзан үздэг.

Сонгогчдын бүртгэлийн алба нь нэмэлт санал авах төвүүдийг үйлчилгээ авахад дутмаг нийгмийн бүлэг болон сонгогчдын нягтрал ихтэй газруудад байрлуулахад анхаарч ажилласан.

### **Сонгуулийн ажилтнуудын бүрэлдэхүүн**

Сонгогчдын бүртгэлийн алба нь сонгуулийн ажилтнуудыг (Сонгуулийн тухай хуульд Сонгуулийн зөвлөл гэж нэрлэнэ) Санал өгөх төвүүдэд ажиллуулахаар ажилд авдаг.

Мужийн хэлний хэрэгцээнд дэмжлэг үзүүлэх үүднээс хоёр хэлтэй аль болох олон сонгуулийн ажилчдыг ажилд авахыг хичээж байна. Сонгогчийн мэдээллийн гарын авлага, тойргийн мэдэгдэл, тойргийн цахим хуудас, хэлний хүртээмжтэй байдлын зөвлөх хороо, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн арга хэмжээ, сонгогчидтой харилцах, мэдээ, шуудан илгээх зэргээр дамжуулан сурталчилгаа хийх зэрэг хүчин чармайлтууд орно. Сонгуулийн ажилчдын бүрэлдэхүүн нь мужийн ажилтнууд болон тэтгэлэгт сайн дурын ажилтнуудаас бүрдэнэ. Сонгуулийн ажилчдыг

үүргийнх нь дагуу сургаж, боломжтой байдлаас нь шалтгаалан арван нэгэн (11) хоног ажиллуулахаар томилдог. Санал өгөх төв бүрд ес (9) хүртэлх Сонгуулийн ажилтан байхаар төлөвлөсөн.

### **Сонгогчдын цахим бүртгэлийн жагсаалт (Электрон таблет)**

Сонгогчийн сонголтын тухай хуулийн өөрчлөлтүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд санал өгөх төвүүдийг сонгогчдын цахим бүртгэлээр хангасан (Сонгуулийн тухай хууль §2183). Цахим бүртгэл нь санал өгөх төвүүд болон сонгогчдын бүртгэлийн албаны өгөгдөл мэдээллийн удирдлагын систем (DIMS) хооронд аюулгүй цахим харилцаа холбоог хангахад ашигладаг цахим техник хангамж ба программ хангамжийн нэгдэл юм. Сонгогчдын бүртгэлийн албаны өгөгдөл мэдээллийн удирдлагын систем нь төрийн нарийн бичгийн даргын албатай мэдээлэл солилцдог. VoteCal нь мужийн сонгуулийн удирдлагын системтэй харилцаж, өгөгдөл солилцдог муж улсын хэмжээний сонгогчийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан юм. Энэ шинэ VCA технологи нь "HARDENED" таблет дээр ажилладаг бөгөөд төхөөрөмж дээр зөвхөн SOS-р баталгаажсан цахим цахим бүртгэлийн программ хангамжийг ажиллуулах боломжтой гэсэн үг юм.

Сонгогчдын цахим бүртгэл нь сонгогчдын бүртгэлийн мэдээллийг (Жагсаалтын индекс) агуулдаг ба санал өгөх төвүүдэд дамжуулж ашигладаг. Жагсаалтын индекс нь сонгуульд санал өгөх эрхтэй, бүртгэлтэй бүх сонгогчийн албан ёсны жагсаалт болно. Үүнийг сонгогчийн саналын хуудас авах эрхийг баталгаажуулах, давхар санал өгөхөөс урьдчилан сэргийлэх, сонгогчийн түүхийг бодит шуурхай авах зорилгоор ашигладаг. Цахим бүртгэлийн таблет нь аюулгүй, ус нэвтэрдэггүй түгжээтэй хамгаалалтын хайрцагтай ба хоёрдогч хамгаалалттай газар хадгалагддаг. Ажлын цагаар эдгээр төхөөрөмжид хадгалагдсан өгөгдөл тасралтгүй шинэчлэгдэж байдаг. Цахим бүртгэлийн таблет нь хэрэглэгчийн хандалтаар програмчлагдсан бөгөөд зөвхөн эрх бүхий хэрэглэгчдэд найдвартай клоуд серверт найдвартай холболтыг ашиглан нэвтрэх боломжийг олгодог. Энэ клоуд сервер нь мэдээллийн сан болон сонгогчдын бүртгэлийн өгөгдөл мэдээллийн удирдлагын системтэй холбогдож сонгогчийн мэдээлэлд шинэчлэлтийг дамжуулж байдаг.

Цахим бүртгэлийн таблетыг сонгогчийн нэр, хаяг, төрсөн огноо, сонгосон хэл, намын сонголт, сонгуулийн хэсгийн хороо, Шуудангаар санал өгөх төлөв зэрэг сонгогчийн бүртгэлийн өгөгдлийг баталгаажуулахад ашиглаж болно. Түүнчлэн цахим бүртгэлийн таблет нь сонгогчийн дараах мэдээллийг хэзээ ч хадгалдаггүй: жолооны үнэмлэхийн дугаар эсвэл нийгмийн даатгалын дугаартай холбоотой лавлагаа. Цахим бүртгэлийн таблет нь сонгогчийн одоогийн статусын мэдээллийг өгөхийн зэрэгцээ сонгогчид болон сонгуулийн ажилчдад санал өгөх явцыг илүү үр дүнтэй болгодог.

### **Хүрч үйлчлэх**

#### *Олон нийтийн хэлэлцүүлэг*

Сонгогчдын сонголтын тухай хуулийн дагуу Аламеда муж сонгуулийг зохион байгуулахтай холбоотой төлөвлөгөөнд олон нийтийн саналыг авах, сонгогчдын мэдлэг, сурталчилгааны зорилгод дараах зүйлс орно:

- Боломжит санал өгөх төвийн байршлууд
- Саналын хуудас өгөх боломжтой газрууд
- Төрөл бүрийн хэлний хүртээмжтэй байх хэрэгцээ
- Сонгогчдын хүртээмжтэй байдлын хэрэгцээг хангах өөр аргууд



- Хэвлэл мэдээлэл, арга хэмжээнүүдээр дамжуулан олон нийтэд хүрч ажиллах зөвлөмж
- Санал өгөх төвүүдийн сонголтуудыг онцолсон Төрийн үйлчилгээний зарлал нь:
  - Бүх нийгэмд чиглэсэн радио, ТВ зар
    - Итгэл үнэмшил дээр суурилсан, ахмад настан, хэл, тусгай хэрэгцээт, орон байргүй, дутуу үйлчилгээтэй, залуучууд, өмгөөллийн бүлгүүд
  - Сайн туршлагын үүднээс тухайн хэлний олон нийт дэх түншүүдээ хөшүүрэг болгох
  - Мэдээ гаргалт, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн бүх байгууллага, олон нийтийн арга хэмжээ, СБА-ны Сонгогчдын боловсрол, хүрч үйлчлэх багаар дамжуулан
- Үнэгүй утас (1-800-834-6454) нь шаардлагатай бүх хэл дээр байх ба үүнтэй холбоотой мэдээлэл нь Сонгогчийн мэдээллийн гарын авлага, шууд шуудан илгээх, Шуудангаар санал өгөх саналын хуудас, олон нийтийн мэдээллийн товхимол, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэгт байх болно.

Түүнчлэн төрийн нарийн бичгийн даргын алба болон сонгуулийн тухай хуулийн 4005 заалтын дагуу 2 болон 4 жилийн дараа сонгуулийн анхны төлөвлөгөөг баталснаас хойш.

Сонгуулийн бүртгэлийн алба нь дараах 6 алхамыг авч хэрэгжүүлнэ:

1. Сонгуулийн зохион байгуулалтын төлөвлөгөөний эхний хувилбарт 14 хоногийн турш олон нийтийн санал авахаар нийтлэх
2. 10 хоногийн өмнө олон нийтийн саналыг сонсох өдрийг товлох
3. Сонгуулийн зохион байгуулах төлөвлөгөөнд олон нийтийн саналыг сонсох өдрийг зохион байгуулах
4. Сонгуулийн зохион байгуулах төлөвлөгөөнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдэд 14 хоногийн турш санал авах
5. Сонгуулийн зохион байгуулах төлөвлөгөөний эцсийн хувилбарыг төрийн нарийн бичгийн даргын албанд батлуулахаар хүргүүлнэ
6. Батлагдсаны дараа сонгуулийн зохион байгуулах хэсэг нь сонгуулийн тухай хуулийн §14201 болон 1965 оны санал г х эрхийн тухай хуулийн 203-р хэсэгт тусгагдсан хэл б рээр сонгуулийг зохион байгуулах т л в л г г мужийн цахим хуудсанд байршуулна.

### *Шууд шуудан илгээгчид*

Хоёр шууд шуудангаар дамжуулан бүх сонгогчид шуудангаар саналын хуудсаа хүлээн авах болно гэдгийг олон нийтэд мэдээлэх болно. Мэдэгдэл нь бүх шуудангаар илгээсэн саналын хуудсаар сонгууль явуулах бөгөөд сонгогчид дараах дөрвөн хувилбарын аль нэгээр саналын хуудсаа өгөж буцаан явуулах боломжтой гэдгийг сонгогчдод мэдээлнэ. Үүнд: Шуудангаар (шуудангийн төлбөр төлсөн дугтуй), саналын хуудас өгөх газар, 24 цаг саналын хуудас өгөх хайрцаг, муж дотор аль нэн санал өгөх төвд. Мэдэгдэлд сонгогчид дараах мэдээллийг авах боломжтой утасны дугаар болон цахим хуудас хаягийг оруулсан болно. Үүнд: чухал огноо, санал өгөх газар, санал өгөх төвүүдийн ажиллах цаг, 24 цаг саналын хуудас өгөх хайрцгийн байршил, саналын хуудас хүлээн авах газар, шуудангаар саналын хуудсаар санал нөхөж өгөхийг хүссэн эцсийн хугацаа. Шууд шуудангаар өгөгдсөн нэмэлт мэдээлэлд санал өгөх төвийн чухал мэдээлэл болон тойргийн сонгогчдын мэдээллийн гарын авлагын дэлгэрэнгүй багтсан болно. Мэдэгдэл нь сонгогчдын

бүртгэлийн цахим хуудас руу орох холбоос, төлбөргүй утасны дугаар, 1(800) 834-6454 холбогдон тусламж хүсэх.

Эхний шууд шуудангийн илгээмжийг сонгууль болохоос ойролцоогоор 90 хоногийн өмнө, дараагийн багцыг сонгууль болохоос ойролцоогоор 29 хоногийн өмнө шуудангаар илгээнэ. Сонгогчийн сонголтын тухай хуультай холбоотой бүх нийтийн мэдэгдэл мэдээллийг сонгогчдын бүртгэлийн цахим хуудсанд байршуулах болно.

*Хэлний хүртээмж, Санал өгөх хүртээмжтэй байдлын зөвлөх хороо, мөн Сонгогчдын мэдлэг болон Өргөнөөр хамрах бодлогын хороо*

Сонгогчдын бүртгэлийн алба нь 2001 оны есдүгээр сард санал өгөх хүртээмжтэй байдлын зөвлөх хороог байгуулж, 2012 оны хоёрдугаар сард хэлний хүртээмжтэй байдлын зөвлөх хороог байгуулсан бөгөөд 30 гаруй жилийн турш эмэгтэй сонгогчдын холбоотой байнгын хамтын ажиллагаатай байсан. Сонгогчдын бүртгэлийн алба нь мөн сонгогчдын боловсролын хөтөлбөрийг өргөжүүлэх, бидний хүчин чармайлтын ахиц дэвшлийн талаар сонгогчдын бүртгэлийн албанд олон нийтийн байр сууринаас ойлголт өгөх, сайжруулах шаардлагатай нутаг дэвсгэрийг тодруулах зорилгоор Сонгогчдын боловсрол, сурталчилгааны зөвлөх хороог (VEOAC) байгуулсан. Түүнчлэн хороо нь оршин суугчдад VCA болон олон нийтийн оролцооны боломжуудын талаар мэдээлэл өгдөг. Мөн сонгогчдын бүртгэлийн алба нь сонгогчдын боловсролын хөтөлбөрийг өргөжүүлэхийн тулд сонгогчдын боловсрол, сурталчилгааны эвслийг байгуулж, оршин суугчдад сонгогчийн сонголтын тухай хууль болон олон нийтийн оролцооны боломжуудын талаар мэдээлэл өгөх зорилготой юм. Сонгогчдын бүртгэлийн алба нь сонгуулийн санал өгөх төвийн загвар, сонгуулийн удирдлагын төлөвлөгөөний төслийг боловсруулахын зэрэгцээ Аламеда мужийн сонгогчдын сонголтын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой санал хүсэлтийг авахын тулд олон нийтийн түншүүдтэйгээ үргэлжлүүлэн хамтран ажиллах болно. LAAC, VAAC, эсвэл VEOAC-ийн нэг хэсэг болохыг хүсвэл [vca@accgov.org](mailto:vca@accgov.org) хаягаар Сонгогчдын бүртгэлийн албанд и-мэйл илгээнэ үү. VAAC болон LAAC улирал бүр хуралддаг. Уулзалтууд нэг цаг үргэлжилнэ.

## **2 дугаар бүлэг – Сонгогчийн сонгуулийн боловсрол болон хүрч үйлчлэх төлөвлөгөө**

Сонгогчдын сонголтын тухай хууль нь сонгогчдын сонголтын тухай хуулийн загвар сонгуулийг хэрэгжүүлж буй аль ч тойрогт сонгогчдод сонгогчдын сонголтын тухай хуулийн заалтуудын талаар мэдээлэл өгөх, сонгогчдын сонгуулийн боловсрол, сурталчилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг үүрэг болгодог. Тодруулбал тус хуульд зааснаар голчлон Англи хэлнээс өөр хэлээр ярьдаг сонгогчид болон тусгай хэрэгцээт сонгогчдод чиглэсэн зорилтод сурталчилгаа ялуулахыг заасан байдаг.

Аламеда мужийн сонгогчдын бүртгэлийн алба нь олон нийтийн оролцоог хадгалахын тулд тухайн жилийн турш олон нийтэд хүрч ажиллах хөтөлбөртэй байдаг. Олон нийтэд хүрч ажиллах хүчин чармайлтуудад сонгогчдын боловсрол олгох, бүртгэлийн үйлчилгээ, төрийн үйлчилгээний мэдэгдэл, арга хэмжээнд оролцох, сонгогчдын хүртээмжтэй байдлын бүлгүүд, хэлний бүлгүүд, олон нийтийн байгууллага, итгэл үнэмшилд суурилсан байгууллагууд, ахлах ангийн сурагчидтай уулзах зэрэг орно. Сонгогчдын бүртгэлийн алба нь Аламеда муж дахь сонгогчдын сонголтын тухай хуулийн талаарх сонгогчдын сонгуулийн боловсролын сургалтыг одоо байгаа олон нийтэд хүрч ажиллах хөтөлбөртөө багтаах болно. Сургалт нь сонгогчийн сонголтын тухай хуулийн тойм, сонгогчдод туслах төв, саналын хайрцгийн байршлын тойм, санал хураах төхөөрөмжийг практик

дээр харуулах зэргээс бүрдэнэ. Сонгуулийн зохион байгуулалтын төлөвлөгөөнд сонгогчдын бүртгэлийн алба нь одоо хэрэгжиж байгаа болон цаашид хэрэгжих аргуудыг хөшүүргэ болгон олон нийтэд сонгогчдын сонголтын тухай хуулийн талаар хэрхэн мэдлэг олгох талаар зураглан гаргадаг. Олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, иргэдийн оролцооны боломжийг өргөжүүлэх, санал өгөх төвийн загвар, сонгогчдын санал өгөх үйл явцыг сайжруулах зорилготойгоор олон нийтэд хүрч ажиллах үйл ажиллагааг зохион байгуулна. Сонгогчдын сонгуулийн боловсрол, сонгогчдод хүрч ажиллах үйл ажиллагааг доор жагсаав.

Сонгогчдын сонгуулийн боловсрол:

- Сонгогчдын сонголтын тухай хууль нь сонгогчдод биечлэн санал өгөх, илүү олон сонголт, илүү олон хоног, илүү олон байршилд санал өгөх боломжийг олгодог талаарх мэдлэгийг олгох
- Бүх байгууллагатай хамтран ажиллах (олон нийт, тусгай хэрэгцээ, итгэл үнэмшилд суурилсан, хэл яриа, ахмад настан, залуучууд)
- Сургалт явуулах
- Залуу сонгогчдыг (ахлах сургууль, коллеж) сонгогчдын сонгуулийн тухай хуулийн загвар сонгуулийн дагуу удахгүй болох сонгуулийн мөчлөгт оролцохыг нь урамшуулах зорилгоор сургах

Сонгогчдод хүрч ажиллах:

- Сонгогчдын бүртгэлийг нэмэгдүүлэхийн тулд олон нийтэд чиглэх
- Нийгмийн бүлгүүдийг сонгогчдод түгээх орчуулсан материалаар хангах
- Жишээ болгон сонгуулийн жинхэнэ явцыг үзүүлж, санал өгөх төхөөрөмжийг бүх хүмүүст танилцуулах (Хэлний хүртээмж болон, санал өгөх хүртээмжтэй байдлын зөвлөх хороо, Ахмад настан, ахлах сургуулийн сургагч)
- Сонгогчдын сонголтын тухай хуулийн талаар байнга асуудаг асуултуудын хариултыг агуулсан мэдээллийн гарын авлага өгөх
- ACVOTE On The Go үйлчилгээ болон саналын хуудасаа хэрхэн өгөх талаар арга хэмжээ зохион байгуулж мэдлэг олгох
- Дараах арга хэмжээнүүдэд оролцоноор олон нийт дундах байр сууриа хадгалах болно. Гудамжны фестиваль, олон нийтийн хэсэг, фермерийн зах, хүсэлтийн дагуух тусгай арга хэмжээ, зэргэлдээх орон нутгийн арга хэмжээ, олон нийтэд түшиглэсэн байгууллагын арга хэмжээ, итгэл үнэмшилд суурилсан байгууллагын арга хэмжээ.

Сонгуулийн зохион байгуулалтын төлөвлөгөөг эцсийн байдлаар нийтэлсний дараа сонгогчдын бүртгэлийн алба нь сонгогчдод зориулсан сонгуулийн мэдлэг олгох сургалтыг Аламеда тойрог, холбооны улс болон мужийн шаардлагын дагуу тухайн хэллүүд дээр зохион байгуулна. Холбооны улсын хэмжээнд Англи, Хятад, Испани, Тагалог болон Вьетнам хэл орно. Мужийн хэмжээнд Бирм, Хинди, Кхмер, Солонгос, Лаос, Миен, Монгол, Пунжаби, Тэлуку хэл орно. Сургалт бүр санал өгөх төвийн загвар, санал өгөх төхөөрөмжийн тойм/үзүүлэн, хэлний тусламжийн үйлчилгээ, саналын хуудас өгөх сонголт, орчуулсан сонгуулийн материалыг хүсэх аргачлалын талаарх мэдээллийг багтаана. Сургалтын талаарх мэдээллийг тов гарахаас 10-аас доошгүй хоногийн өмнө зарлаж, LAAC, VAAC, VEOAC болон хэлний олон нийтийн байгууллагуудтай хуваалцах болно.

## **1 дүгээр хэсэг: Сонгогчтой холбоо барих – Ерөнхий**

Сонгогчдын бүртгэлийн алба нь олон нийт болон бүх нийгмийн бүлэгт сонгогчдын сонголтын тухай хуулийн талаар сонгогчдын боловсрол олгохын зэрэгцээ олон нийтийн оролцоотой хэвээр байх болно. Сонгогчдын бүртгэлийн алба нь ирэх сонгуулийн талаар хэлний цөөнхийн нийгмийн бүлэгт мэдээлэл өгөх, сонгогчдод тусламж үзүүлэх үнэ төлбөргүй шууд утсыг сурталчлах, шуудангаар санал өгөх, шуудангийн саналын хуудсаар санал өгөх хүсэлт гаргах үйл явцыг мэдээлэхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим платформыг ашиглах болно.

2022 оны 1 дүгээр сараас 2023 оны 4 дүгээр сарын хооронд Сонгогчдын бүртгэлийн алба нь сонгогчдод боловсрол олгох, олон нийтэд хүрч ажиллах, нийгмийн бүлэг тус бүрээс хийж буй ажилтай танилцах зорилгоор олон нийтэд чиглэсэн 171 арга хэмжээнд оролцов. Сонгогчдод сонгуулийн боловсрол олгох хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд олон нийтэд түшиглэсэн байгууллага, бүх нийгмийн бүлэгтэй хамтран ажиллах зорилготой.

### *Хэвлэл мэдээллийн хэрэглээ*

Сонгогчдын бүртгэлийн алба нь санал өгөх төвийн загвар сонгууль, шуудангаар санал өгөх үйл явц, хугацаанаас өмнө санал өгөх сонголтууд, зорилтот хэвлэл мэдээллийн кампанит ажилд санал өгөх төвд ажиллах боломжуудын талаар мэдээлэл өгөх болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн боломжуудад дараах зүйлс багтах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

### **Телевиз**

Комкэст  
PBS / KQED  
Ипоч Таймс/ NTD TB  
KTSF26  
Скай Линк ТВ  
TVB USA  
Кроссинг ТВ  
Юнивишн  
Телемундо  
Эстрелла ТВ  
ЭйБиЭн-СиБиЭн мэдээ  
SBTN  
Нгюой Вьет ТВ  
Труен Хин Кали Өнөөдөр  
Namaste ТВ

### **Хэл**

Англи  
Англи  
Хятад  
Хятад/Тагалог  
Хятад  
Хятад  
Хятад, Тагалог, Хинди Вьетнам/Пунжаби  
Испани  
Испани  
Испани  
Тагалог  
Вьетнам  
Вьетнам  
Вьетнам  
Хинди

### **Сонин, мэдээллийн товхимол**

Баруун Энэтхэг  
Меркюри Ньюс  
Ийст Бэй Таймс  
Ийст Бэй Экспресс  
Окланд Пост

### **Хэл**

Англи  
Англи  
Англи  
Англи  
Англи

Өдөр тутмын Калифорни (UC Berkeley)	Англи
Анхдагч (CSU Hayward)	Англи
Тусгаар тогтнол	Англи
Аламедагийн нар	Англи
Окланд Трибюн	Англи
ЭЛ Серрито вайр	Англи
Долоо хоног тутмын Плийсантон	Англи
Экспресс (Las Positas коллеж)	Англи
Сурвалжлагч (Аламеда-н коллеж)	Англи
Иргэн (Peralta Олон нийтийн коллежийн дүүрэг)	Англи
Кампанил (Mills коллеж)	Англи
Дэлхийн Сэтгүүл	Хятад
Өдөр тутмын Тао дуулал	Хятад
Ипоч Таймс	Хятад/Англи/Вьетнам
Сар тутмын Хералд	Хятад
ЭЛ Обзервадор	Испани
Испанийн Алсын хараа	Испани
Микстеко Индигена олон нийтийн зохион байгуулах төсөл (Mixteco Indigena Community Organizing Project)	Испани
Филиппиний өнөөдрийн мэдээ	Тагалог
Азийн сэтгүүл	Тагалог
Танг Мо	Вьетнам
Нгюой Вьет Дэйли Ньюс	Вьетнам
India Currents	Хинди
Korea Times SF	Солонгос
Korean Hyundai Weekly	Солонгос

### **Радио**

KBAY/KEZR
KALX (Berkeley)
KCRH (Hayward)
KQED-FM
KKSF (Oakland)
KNEW (Oakland)
KPFB (Berkeley)
KOHL (Fremont)
KPFA (Berkeley)
KKIQ (Livermore)
KBLX-FM (Berkeley)
KALW
Найдварын дуу
Хятадын Тао дуулал / KVTO (Berkeley)
KEST AM1450

### **Хэл**

Англи
Англи
Англи
Англи
Англи
Англи
Англи
Англи
Англи
Англи
Англи
Англи
Хятад
Хятад
Хятад

Юнивишн  
KSFN (Piedmont)  
KMKY (Oakland)  
Korean American Radio

Испани  
Испани  
Хинди, Пунжаби  
Солонгос

### **Олон нийтийн сүлжээ**

ACVOTE Facebook [www.facebook.com/acvote](http://www.facebook.com/acvote)

Alameda тойргийн Facebook

ACVOTE Twitter [www.twitter.com/acvote](http://www.twitter.com/acvote)

Alameda тойргийн Twitter

ACVOTE Instagram

[www.instagram.com/acvote](http://www.instagram.com/acvote)

Тойргийн мэдээний тоймын захиалгын  
жагсаалт

ACVOTE YouTube [www.youtube.com](http://www.youtube.com)

ACVOTE хайх

[www.ACVOTE.org](http://www.ACVOTE.org) Вебсайт

ACGOV.org Вебсайт

Мөн Сонгогчдын бүртгэлийн алба нь Аламеда муж дахь BART станцууд, AC транзит автобуснууд болон дижитал сурталчилгааны самбарууд дээр мэдээллээ сурталчилдаг.

Манай алба жилийн туршид муж даяарх нийгмийн бүлгийн түншүүд, тусгай хэрэгцээт иргэдийн өмгөөлөгчдийн байгууллага, сонгогдсон албан тушаалтнууд, тусгай дүүрэг, сургуулийн дүүрэг, олон нийтэд түшиглэсэн байгууллага, итгэл үнэмшилд суурилсан байгууллагууд зэрэг бүлгүүдтэй материал хуваалцахад анхаарлаа төвлөрүүлэх болно. Мэдээллийг манай вебсайтаас болон хэвлэмэл хэлбэрээр авах боломжтой. Сонгогчдын бүртгэлийн алба сонгогчдод мэдлэг олгоход ашиглах шинэ хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг үргэлжлүүлэн хайх болно.

Сонгогчдын бүртгэлийн алба нь ирэх сонгууль бүрийн талаар сонгогчдод мэдээлэхийн тулд хүртээмжтэй форматаар өргөнөөр түгээх аудио болон дүрсний хэрэгслийг ашиглана. Зорилго нь дүлий, сонсголын бэрхшээлтэй, хараагүй, харааны бэрхшээлтэй сонгогчид гэх мэт тусгай хэрэгцээт сонгогчдыг оруулаад тойргийн бүх сонгогчдод хүргэх юм.

### **Олон нийтийн оролцоо ба сонгогчдод мэдлэг олгох материал**

Сонгогчдын бүртгэлийн алба нь бүтэн жилийн туршид олон зуун олон нийтийн арга хэмжээнд оролцдог. Олон нийтийн оролцоондоо туслахын тулд бид товхимол, манай цахим хуудасны холбоос, Сонгогчдыг сонголтын тухай хуультай холбоотой ухуулах хуудас зэрэг сонгуулийн боловсролын материалыг өгөх болно. Сонгогчдын бүртгэлийн алба нь сонгогчдод санал өгөх сонголтынх нь талаар мэдээлж, санал өгөх төвөөс хүртээмжтэйгээр санал өгөх машин, шаардагдах хэмжээний саналын хуудас, шаардагдах хэмжээний сонгогчийн мэдээллийн гарын авлагыг үзүүлэх болно. Хэлний материалыг шаардлагатай хэл дээр нь хангана. Сонгогчийн бүртгэлийн ангид манай оффистой холбогдож эсвэл манай вебсайт руу орж хүсэлт ирүүлэх боломжтой. Удахгүй болох аливаа өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлэх шилдэг аргуудыг хэлэлцэж, тодорхойлох болон сонгогчдын оролцоог нэмэгдүүлэхийн тулд сонгогчдын бүртгэлийн алба нь тойрог даяарх нийгмийн бүлгийн түншүүдтэй үргэлжлүүлэн уулзах болно. Зааварчилгааны материалаар хангаж, сонгогчдын бүртгэлийн албаны ажилтнууд сонгогчдын сонголтын тухай хуулийн талаар сонгогчдын боловсролд дэм үзүүлэх болно.

Олон нийтийн оролцоо ба сонгогчдын боловсролын материалууд:

- CIL (Бие даан амьдрах төв)
- CRIL (Бие даан амьдрахад зориулсан олон нийтийн нөөц бололцоо)
- Тусгай хэрэгцээт иргэдийн нийгэмлэгүүд
- Итгэл үнэмшилд суурилсан нийгмийн бүлэг
- Хэлний хүртээмжтэй байдлын зөвлөх хороо
- LGBTQ+ нийгмийн бүлэг
- LWV (Эмэгтэй сонгогчдын лиг)
- Олон нийтийн арга хэмжээ/тусгай арга хэмжээ
- Ахмадын нийгэмлэгүүд
- Үйлчилгээ хүртэгч
- Орон гэргүй
- USCIS (United States-н Иргэншил, Цагаачлалын алба)
- Санал өгөх хүртээмжтэй байдлын зөвлөх хороо
- Залуучуудад суурилсан нийгмийн бүлэг (ахлах сургууль, коллеж)

## **Шууданг шууд илгээх**

Сонгогчдын бүртгэлийн алба нь Аламеда мужийн бүртгэлтэй сонгогч бүртэй хоёр (2) тусдаа шуудангаар холбогдож, сонгогчдод сонгогчдын сонголтын тухай хуулийн санал хураалтын загвар болон удахгүй болох сонгуулийн талаар мэдээлэх, сонгогчдод туслах (800) 834-6454 үнэгүй утсыг сурталчлах болно. Энэхүү шуудангаар сонгуулийн шинэ загвар болон ирэх сонгуульд санал өгөх хувилбаруудын талаар сонгогчдод мэдээлэл өгөх юм. Сонгогчид аливаа өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон санал өгөх төв, саналын хуудас өгөх газруудын ажиллах огноо, байршил, цагийг харах боломжтой холбоосыг мэдэж авах боломжтой. Англи хэлнээс өөр хэл сонгосон бүртгэлтэй сонгогчдод тараахын тулд шуудангийн илгээмж бүрийг сонгогчдын хэлний сонголтоос хамааран дөрвөн (4) хэл рүү орчуулах болно. Сонгуулийн бүртгэлийн газар нь Англи хэлний мэдлэг хязгаарлагдмал сонгогчдод өөрийн хэлний сонголтоо шууд шуудангийн ар талд, сонгогчийн мэдээллийн гарын авлага, шуудангаар санал өгөх багц, олон нийтийн сүлжээ, миний сонгогчийн профайлаар дамжуулан шинэчлэгдсэн олон хэлний зааварчилгааг өгөх болно.

Бүртгүүлсэн бүх сонгогчдод тэдгээрийн сонгогчийн мэдээллийн гарын авлага дахь шуудангийн төлбөртэй ил захидлыг илгээх бөгөөд ингэснээр тэд Калфорнийн сонгуулийн тухай хуулийн §14201, холбооны сонгуулийн эрхийн тухай хуулийн §203-д тус тус заасны дагуу шуудангаар санал өгөх саналын хуудсыг хүлээн авах боломжтой хэлбэрээр хүсэж, сонгуулийн материалыг өөр хэлээр авах хүсэлт гаргах боломжтой. Ил захидлыг бөглөх, буцаан хүргүүлэх зааварчилгааг сонгогчийн мэдээллийн гарын авлага болон сонгогчдын бүртгэлийн албаны цахим хуудаст оруулна.

## **Сонгогчдод мэдлэг олгох цахим хуудас**

Сонгогчдын сонголтын тухай хуулийн талаарх мэдээлэл зэрэг СБА-ны сонгогчдод зориулсан боловсролын бүх материалыг Англи, Хятад, Испани, Тагалог, Вьетнам хэлээр цахим хэлбэрээр СБА-ны вэбсайтад байршуулсан. Сонгогчдын бүртгэлийн албаны вэбсайт нь дараах мэдээллийг агуулна:

- Сонгогчдын бүртгэлийн албаны талаарх ерөнхий мэдээлэл
- Санал өгөх төвийн ажиллах цаг, 24 цаг саналын хуудас өгөх хайрцгийн байршил

- Сонгогчдын бүртгэлийн албанаас сонгогчдод үнэ төлбөргүй үзүүлэх тусламж
- Шууд утас 1-800-834-6454 болон 510-267-8683 (санал өгөх)
- Сонгуулийн зохион байгуулалтын төлөвлөгөө
- Сонгогчдын сонголтын тухай хуулийн сурталчилгааны материал
- Сонгогчдын сонголтын тухай хуулийн видео танилцуулга
- Олон нийтэд хүрэх ажил болон сургалтын хуваарь
- Санал өгөх төвүүдэд биечлэн хэлний тусламж авах боломжтой байдал

## **2 дугаар хэсэг: Сонгогчтой холбоо барих – Хэлний цөөнхийн бүлэг**

Сонгогчдын бүртгэлийн алба нь Англи хэлнээс өөр хэлээр голчлон ярьдаг сонгогчдод илүү сайн үйлчлэх зорилгоор хэлний хүртээмжтэй байдлын зөвлөх хороог байгуулсан. Энэхүү хороо нь санал өгөх төвийн загвар сонгуулиас бусад хэл дээр ярьдаг нийгмийн бүлгүүдийг сонсож санал авахаар байгуулагдсан. Сонгогчдын бүртгэлийн алба нь санал өгөх төвийн байршил, онцлог, үзүүлэх эсвэл үзүүлэх ёстой үйлчилгээний талаар санал өгөх хэлний хорооны гишүүдтэй уулзах болно. Энэхүү хороо нь цаашид ч улирал тутам хуралдаж, олон нийтийг сонсож, хамтран ажиллах болно. Уулзалтын тов, LAAC-д хэрхэн оролцох болон/эсвэл нэгдэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл манай [www.acvote.org](http://www.acvote.org) вебсайтад зочилно уу.

### *Хэлний цөөнхийн нийгмийн бүлгүүдийг тодорхойлох*

Хэлний цөөнхийн нийгмийн бүлгүүдийг Аламеда муж дахь бүртгэлтэй сонгогчдын сонгосон хэлний хүсэлт дээр үндэслэн тодорхойлж болно. Энэхүү мэдээллийг ашиглан хүн амын тооллогын мэдээлэл болон бусад олон нийтэд нээлттэй хүн ам зүйн мэдээллийг хамтатган нь хэлний давамгайлсан бүс нутгийг зурагладаг. Нэмж дурдахад, Муж улсын захирагчийн сонгууль бүрийн өмнө Төрийн нарийн бичгийн дарга нь аль тойрогт 3%-иас дээш (Сонгуулийн тухай хууль §14201) нэг хэлний цөөнх байгааг баталгаажуулсан мэдээллийг тойргуудад өгдөг. Тухайн тойргийн аль хэсэгт ямар хэлний дэмжлэг хэрэгтэйг тодорхойлохын тулд энэ мэдээллийг манай газрын зургийн хэсэгт давхцуулсан болно. Олон нийтэд хүрэх ажил нь төлөвлөсөн сонгогчдын боловсрол, сурталчилгааны нэг хэсэг болгон эдгээр газарт төвлөрөхөд чиглэсэн болно. Сонгогчдын бүртгэлийн алба нь оролцоход ашигтай байж болох олон нийтэд хүрэх ажил болон нийгмийн бүлгүүдийн арга хэмжээний хэлний хэрэгцээ, арга замыг тодорхойлохын тулд хэлний цөөнхийн нийгмийн бүлгүүдээс санал авахыг мөн эрэлхийлж байна.

### *Үйлчилгээнд хамрагдах хэлний цөөнхийн нийгмийн бүлгүүд*

Сонгогчдын бүртгэлийн алба нь одоогоор Англи хэлийг оруулаад арван дөрвөн (14) хэлээр үйлчилгээ үзүүлж байна. Таван хэл нь холбооны шаардлага юм. Англи, Хятад, Испани, Тагалог болон Вьетнам. Есөн хэлэнд мужийн эрх олгосон: Бирм, Хинди, Кхмер, Солонгос, Лаос, Миен, Монгол, Пунжаби, Тэлуку. 24 цаг саналын хуудас өгөх хайрцгийн тэмдэглэгээ болон тойргийн сонгогчдын мэдээллийн хөтөч (VIG-ууд) нь шаардлагатай хэл дээр байх болно. Тодорхой хэлний нийгмийн бүлгүүдийн зураглал болон онилоход үндэслэн сонгогчдын бүртгэлийн алба нь янз бүрийн нийгмийн бүлэгт хоёр хэлээр ярьдаг сонгуулийн ажилтны хэлбэрээр зохих хэлний дэмжлэгийг байрлуулахыг зорино. Санал өгөх төвийн боловсон хүчнийг эцэслэн шийдвэрлэсний дараа сонгогчдын бүртгэлийн алба нь санал өгөх төв бүр дээр биечлэн хэл ярианы тусламж авах боломжтой байдлын талаарх мэдээллийг сонгогчдын бүртгэлийн алба цахим хуудас нийтлэх болно. Сонгогчдын бүртгэлийн алба нь манай вебсайт, хэл дээр суурилсан түншүүд, сонгогчдын



бүртгэлийн алба сургалтууд болон орон нутгийн эрх зүйн байгууллагаар дамжуулан олон нийтийн оролцоог эрэлхийлж байна.

### *Хэлний цөөнхийн нийгмийн бүлгүүдэд зориулсан сонгогчдын сонгуулийн боловсролын сургалт*

Сонгогчдын бүртгэлийн алба нь өмнө дурдсан хэл бүрд дор хаяж нэг (1) удаа хоёр хэлээр сонгогчдын боловсрол олгох сургалт явуулна. Сургалтууд нь Аламеда муж дахь хэлний нийгмийн бүлгүүдэд заасан хэл болгон дээр байгаа материал, тусламжаас гадна санал өгөх төвийн загвар сонгуулийн үйл явцын талаар мэдээлэл хүлээн авах боломжийг олгоно. Сэдвүүд нь факсын саналын хуудас, боломжит орчуулгын үйлчилгээ авах хүсэлт гаргах, сонгогчид хэрхэн хүсэлт гаргах зэргийг хамарна. Сургалт болох газар, огноог сонгохын тулд Сонгогчдын бүртгэлийн алба нь хэлний хүртээмжтэй байдлын зөвлөх хорооны гишүүдийн саналыг ашиглах болно. Бүх сургалт оролцогчдыг дэмжих хэлний тусгай орчуулагчтай байх болно.

### *Хэлний цөөнхийн нийгмийн бүлэгт чиглэсэн хэвлэл мэдээллийн хэрэглээ*

Сонгогчдын бүртгэлийн алба нь энэхүү баримт бичгийн 1-р хэсэгт (Хэвлэл мэдээллийн хэрэгслийн ашиглалт) иш татсан хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглаж радио, телевизийн олон нийтийн үйлчилгээний зарлалыг ашиглан санал өгөх төвийн загвар сонгуулийн дагуу санал өгөх боломжуудын талаар хэлний цөөнх олон нийтэд мэдээлэл өгөх болно. 1-р хэсэгт жагсаасан хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрөлд телевиз, радио, сонин, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл орно.

- Орчуулсан материал болон орчуулгын үйлчилгээ зэрэг Санал өгөх төвүүдийн хэлний хүртээмжийн сонголтыг онцолсон радио, телевизийн олон нийтийн үйлчилгээний зарлал нь:
  - Бүх арван дөрвөн хэл бүхий олон нийтэд чиглэсэн ТВ зар
  - Сайн туршлагын үүднээс тухайн хэлний олон нийт дэх түншүүдээ хөшүүрэг болгох
  - Олон нийтийн мэдээний захидал, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэлний байгууллага, олон нийтийн арга хэмжээ, хэлний хүртээмжтэй байдлын зөвлөх хороо
- Үнэгүй утас (1-800-834-6454) нь шаардлагатай бүх хэл дээр байх ба сонгогчийн мэдээллийн гарын авлага, шууд шуудан илгээх, шуудангаар санал өгөх саналын хуудас, олон нийтийн мэдээний захидал, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэгт байх болно

### *Сонгуулийн ажилтнууд*

Санал өгөх төвийн ажилтнуудын бүрэлдэхүүнийг тодорхойлохын тулд сонгогчдын бүртгэлийн алба нь сонгуулийн ажилчдыг ажилд авна (Сонгуулийн тухай хуулийн Сонгууль, 12-р хэсэг, 4-р бүлгийн 1-р зүйлээс Сонгуулийн зөвлөл гэж иш татсан). Санал өгөх төвүүдийн орон тооны ажилчдыг сонгуулийн санал авах өдөртэй ойр байгаа байдал, санал өгөх төвийн хэмжээний аль алинд нь үндэслэн авч үзнэ. Санал өгөх төв бүрийг ес (9) хүртэл Сонгуулийн ажилтантай байлгах төлөвлөгөөтэй байна.

Сонгогчдын бүртгэлийн алба нь хэлний шаардлагад үндэслэн ажилчдыг ажилд авна. Сонгуулийн ажилчдыг хэлний чадвараар үнэлсэн. Санал өгөх төвийн сонгуулийн өмнөх туршлагыг үнэлсэн. Ажилд авах баг нь өмнөх сонгуулиудад ажилласан туршлага дээр үндэслэн тухайн ажилтны хамгийн сайн үүргийг тодорхойлдог бөгөөд энэ ажилчдад тодорхой сургалт явуулах үүрэг өгдөг. Хэрэв сонгогчид хэлний тусламж шаардлагатай байхад тэр газарт тухайн хэлээр ярьдаг сонгуулийн ажилтан байхгүй бол сонгогчдод туслахын тулд Сонгогчдын бүртгэлийн газрын манай хэлний дэмжлэг үзүүлэх утас руу залгах болно.

### **3 дугаар хэсэг: Сонгогчтой холбоо барих – Тусгай хэрэгцээт сонгогч**

Сонгогчдын бүртгэлийн алба нь тусгай хэрэгцээт сонгогчдын санаа оноог эрэлхийлэх үүднээс санал өгөх хүртээмжтэй байдлын зөвлөх хороотой удаан хугацаанд тогтоосон хамтын ажиллагаатай. Энэхүү хороо нь санал өгөх төвийн байршил, түүнчлэн үзүүлэх эсвэл үзүүлэх ёстой онцлог болон үйлчилгээний талаар санал хүсэлтээ өгөх болно. Энэхүү хороо нь цаашид ч улирал тутам хуралдаж, олон нийтийг сонсож, хамтран ажиллах болно. Уулзалтын тов, VAAC-д хэрхэн оролцох болон/эсвэл нэгдэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл манай [www.acvote.org](http://www.acvote.org) вебсайтад зочилно уу.

#### *Тусгай хэрэгцээт сонгогчдын хэрэгцээг тодорхойлоход ашигладаг аргууд*

Сонгогчдын бүртгэлийн алба нь тойрог даяарх тусгай хэрэгцээт сонгогчдын хэрэгцээнд үргэлжлүүлэн анхаарлаа хандуулах болно. Сонгогчдын бүртгэлийн алба нь 2001 онд санал өгөх хүртээмжтэй байдлын зөвлөх хороог байгуулж, хамтын харилцаатай хэвээр байна. Сонгогчдын бүртгэлийн алба нь Аламеда муж дахь сонгогчдын сонголтын тухай хуультай хамааралтайн хувьд тусгай хэрэгцээт сонгогчдын хэрэгцээг тодорхойлохын тулд санал өгөх хүртээмжтэй байдлын зөвлөх хороогтой хамтран ажиллана. Сонгогчдын бүртгэлийн алба нь тусгай хэрэгцээт иргэдийн сонгогчдын санал зөвлөмжийг хянаж үзэх үүрэгтэй.

#### *Тусгай хэрэгцээт нийгмийн бүлэгт хүрч ажиллах*

Сонгогчдын бүртгэлийн алба нь хэвлэл мэдээллийн ерөнхий кампанит ажлаас гадна хүртээмжтэй байдлын хэрэгцээний үүднээс сонгогчдод мэдээлэл өгдөг. Үүнд санал өгөх төв бүрд санал өгөх төхөөрөмж боломжтой эсэх мэдээлэл, мөн зайнаас шуудангаар санал өгөх системийг ашиглах сонголтууд багтана. Шууд санал өгөх системийг санал өгөх эрх бүхий бүртгэлтэй бүх хүмүүс ашиглах боломжтой.

Тусгай хэрэгцээт иргэдэд мэдээлэл өгөх, хүрч ажиллах бусад боломжуудад дараах орно:

- CRIL, The Ed Roberts Campus зэрэг ахмад настан эсвэл тусгай хэрэгцээт хүмүүст үйлчилгээ, дэмжлэг үзүүлдэг байгууллагууд
- Олон нийтийн түншүүд, хотууд, тусгай дүүрэг, сургуулийн дүүрэг, итгэл үнэмшилд суурилсан байгууллага, олон нийтэд түшиглэсэн олон төрлийн байгууллагууд;
- Санал өгөх хүртээмжтэй байдлын зөвлөх хороо ;
- Хүртээмжтэй санал хураах машин ашиглан практик үзүүлбэрийг хийж үзэх үүднээс сонгогчид болон Сонгуулийн ажилтнуудад зориулсан жилийн турш хийдэг "Нээлттэй хаалганы өдөрлөг"-өөр онцолсон хүртээмжийн сонголтууд;
  - Ажлын цаг сонгогчдын бүртгэлийн албанд
  - Сонгогчийн Мэдээллийн Гарын Авлага, шууд шуудан илгээх мөн [www.acvote.org](http://www.acvote.org) дээр бүхий л мэдээллүүд байх байх болно
- Хүртээмжтэй санал өгөх төхөөрөмж, санал өгөх боломжтой материал зэрэг Санал Өгөх Төвүүдийн хүртээмжийн сонголтуудыг онцолсон радио, телевизийн олон нийтийн үйлчилгээний зарлал нь:
  - Сонголын бэрхшээлтэй, дүлий хүмүүст зориулсан хаалттай тайлбартай ТВ зар эсвэл Америк дохионы хэл

- Сайн туршлагын үүднээс тусгай хэрэгцээт олон нийт дэх түншүүдээ хөшүүрэг болгох
- Олон нийтийн үйлчилгээний зарлалыг хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэдийн нийгэмлэгийн гишүүдэд хүртээмжтэй болгох зураглалаас үл хамаарах аман тайлбар бүхий зарлал болон
- Олон нийтийн мэдээний захидал, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тусгай хэрэгцээт иргэдийн байгууллагууд, олон нийтийн арга хэмжээ, Санал өгөх хүртээмжтэй байдлын зөвлөх хороо
- Үнэгүй утас (1-800-834-6454) нь Сонгогчийн Мэдээллийн Гарын Авлага, шууд шуудан илгээх, Шуудангаар Санал Өгөх Саналын Хуудас, олон нийтийн мэдээний захидал, болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэгт байх болно,
- Сонголгүй эсвэл сонголын бэрхшээлтэй сонгогчид (510) 208-4967 дугаарын утсаар холбогдож болно

### *Тусгай хэрэгцээт сонгогчдод зориулсан үйлчилгээ*

Санал өгөх бүх төвүүд Америкийн тусгай хэрэгцээт иргэдийн тухай хуулийг дагаж мөрддөг. Нэмж дурдахад, Санал өгөх төвүүд нь Америкийн тусгай хэрэгцээт иргэдийн тухай хуульд нийцсэн онцлогууд бүхий саналын хуудасны тэмдэглэгээний төхөөрөмжөөр тоноглогдсон нь тусгай хэрэгцээт сонгогчдод бие даасан, нууцлалтайгаар санал өгөх боломжийг олгодог. Гэртээ тав тухтай орчинд саналаа өгөхийг хүсэж буй сонгогчдод шуудангаар санал өгөх системд хандах сонголт мөн бий. Шуудангаар санал өгөх системийг ашиглан санал өгөх сонгогчид сонгогчдын бүртгэлийн алба вебсайт ([www.acvote.org](http://www.acvote.org)) дээрх My Voter Profile руу нэвтэрч, саналын хуудсаа хэрхэн хэвлэх, бөглөх, саналаа өгсөн саналын хуудсаа сонгогчдын бүртгэлийн албанд буцааж өгөх зааврын хамт Албан ёсны саналын хуудсыг татаж авах боломжтой. Сонгогчдын талаарх ерөнхий мэдээлэл авах бол тусгай хэрэгцээт сонгогчид сонгогчдын бүртгэлийн алба -ийн 1-800-834-6454 дугаартай үнэ төлбөргүй шууд утсаар тусламж авах боломжтой. Сонгогчдын бүртгэлийн алба нь хүсэлт гаргасан тохиолдолд Сонгогчийн мэдээллийн гарын авлагын томоохон хувийг өгнө.

Сонгогчдыг асуулт асуух, санал хураалт болон сонгуулийн талаарх мэдээллийг авах зорилгоор хандаж болох функц руу чиглүүлэх үүднээс олон нийтийг сонгогчийн үнэгүй утсаар хангана. Үнэгүй утасны дугаарыг Сонгогчдын Бүртгэлийн албаны цахим хуудас нийтэлж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сонгогчийн шууд холбоо барих мэдээлэл, үүнд Сонгогчийн Мэдээллийн Гарын Авлага, шууд шуудан илгээх, СБА-ны Вебсайт, Шуудангаар Санал Өгөх багц дотор байрлуулна. Сонголын бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй сонгогчид 711 дугаарт залгаж, California-ий Релей Үйлчилгээг (CRS) ашиглан мессежийн утас (TTY) эсвэл өөр төхөөрөмжөөр дамжуулан утасны системийг ашиглан Сонгогчдын Бүртгэлийн Албаны сонгогчийн үнэгүй утсаар холбогдох боломжтой. CRS нь дараах харилцааны горимуудыг дэмждэг: TTY, VCO, 2LVCO, HCO, STS, VASTS, ASCII, эсвэл Дуу хоолой.

### *Тусгай хэрэгцээт нийгмийн бүлэгт зориулсан Сонгогчдын боловсролын сургалт*

Тусгай хэрэгцээт сонгогчид болон ахмад настанд боломжит хүртээмжтэй байдлын сонголтууд болон Санал өгөх төвийн үйл явцын талаар мэдээлэл өгөх үүднээс сонгогчдын бүртгэлийн алба дор хаяж нэг (1) сонгогчийн боловсрол олгох сургалт зохион байгуулна. Сургалт нь Санал Өгөх Төвийн загвар сонгуулийн тухай боловсрол, санал өгөх төхөөрөмжийн үзүүлэн, санал өгөх төхөөрөмжид хандах боломж, 24 цаг Саналын Хураах хайрцгийн мэдээлэл, цахимаар Шуудангаар Санал Өгөх Саналын Хуудсыг олж авах сонголтуудыг багтаана. Сургалт хийх газар, огноог сонгохын тулд сонгогчдын бүртгэлийн алба нь санал өгөх хүртээмжтэй байдлын зөвлөх хорооны гишүүдээс гаргасан саналыг ашиглана.

*Тусгай хэрэгцээт сонгогчдыг сургахад ашигласан материал ба арга*

Сонгогчдын бүртгэлийн алба нь мэдээлэл түгээхэд ашиглах аудио, визуал, бичгийн материалыг туурвина; тусгай хэрэгцээт сонгогчдыг боловсруулахад ашиглах аргачлалыг боловсруулах явцад сагал өгөх төвийн хүртээмжтэй байдлын зөвлөх хорооны хурлаас цуглуулсан мэдээллийг ашиглана. Материалуудыг сонгогчдын бүртгэлийн алба цахим хуудас эх сурвалж болгон ашиглах боломжтой болно. Сонгогчдын сонголтын тухай хуулийн сурталчилгаа болон сонгуулийн мэдээллийн зорилгоор боловсруулж буй видеонуудын хаалттай тайлбарыг Сонгогчдын бүртгэлийн албаны дэлгэц уншигч ашиглах боломжтой вебсайт (WCAG 2.1 Level AA-д нийцсэн) эсвэл манай оффистой холбогдож авах боломжтой болно.

### Сонгуулийн ажилтнууд

